

**Дэлхийн Банк**

**Монгол орны  
Байгаль орчны  
Хяналт шинжилгээ- 2003**

## Агуулга

Өмнөх үг

Оршил

Товчлол ба хураангуйлал

Байгаль орчны газрын зураг

Байгаль орчны үзүүлэлт: Хандлага ба шинж тэмдэг

Ногоон үзүүлэлт

Ойн нөөц

Биологийн төрөл зүйл ба тусгай хамгаалалттай газрууд

Газрын асуудал: 1990-2000 оны ахуй амьдрал болон малын тоо  
толгойн өөрчлөлт

Хөх үзүүлэлт

Усны нөөц

Хүрэн үзүүлэлт

Усны чанар

Агаарын чанар

Хатуу болон аюултай хог хаягдал

Байгаль орчны байгууллагын бүтэц

Байгаль орчны хууль тогтоомж

Байгаль орчны зардал

Хандивлагчдын тусламж дэмжлэг

Байгаль орчны нэр томъёоны тайлбар

Монгол орны тухай товч мэдээлэл

## ӨМНӨХ ҮГ

Миний бие саяхан хахир- хүйтэн, урт өвөл болон халуун, зудад өртөмтгий зуны улиралтай, харьцангуй том газар нутагтай эх газрын Монгол улсад хийсэн анхны удаагийн айлчлалаа өндөрлөсөн юм. Би харьцангуй богино хугацаанд Монгол улстай танилцсан билээ. Монгол орны хөрс, түүний ургамал эмзэг бөгөөд байгалийн нөөцийн зүй зохисгүй ашиглалтыг нөхөн сэргээгдэхээс өмнө дааж чадахуйц дэлхийд хүн амын нягтшилтаараа хамгийн багатай улс байж болох юм.

Сүүлийн 7 жилд Дэлхийн банк Монгол улсад байгаль орчны менежментийн чиглэлээр төрөл бүрийн хөтөлбөр боловсруулахад туслалцаа үзүүлж байна. Хөтөлбөрүүдийг боловсруулахад Байгаль орчны яам, эрдэмтэд, Буддын шашны нийгэмлэг болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж ирлээ. Тус банкны дэмжлэгтэйгээр ижил төстэй санаачилга гаргаж, тухайлбал ойн салбарт, эдгээр хамтын хүчин чармайлтыг цаашид улам өргөжүүлэн бэхжүүлнэ гэдэгт бид итгэлтэй байна.

Энэхүү Монгол орны байгаль орчны хяналт- шинжилгээ ном нь Зүүн Азийн орнуудад хэвлэгдэн гарч буй ижил төстэй дугааруудын хамгийн сүүлийнх нь юм. Энэхүү номны монгол орчуулга мэдээлэл өгөх зорилгоор арван жилийн дунд болон их, дээд сургуулиудад өргөнөөр тараагдах болно. Түүнчлэн та бүхнийг Улаанбаатар хот дахь манай байгууллагын шинэ мэдээллийн төвөөр үйлчлүүлэхийг бид урьж байна. Энэ маягаар Монгол улсын ирээдүй хойч үедээ цэвэр, аюулгүй байгаль орчныг өвлүүлэн үлдээх зорилгоор олон олон хүмүүс нээлттэй болон бүтээлч яриа, хэлэлцүүлэг болон үйл ажиллагаанд оролцоно гэдэгт бид найдаж байна.

Жэймс Д. Волфенсон  
Дэлхийн Банкны Ерөнхийлөгч

## Оршил

Монгол орны гайхамшигт байгаль, төрөл бүрийн экосистем, ховор амьтан, ургамлын төрөл зүйл нь даян дэлхийд чухал ач холбогдолтой бөгөөд улс орны сайн сайхан амьдралын цөм билээ. Гэвч газар болон байгалийн бусад нөөцөд учрах аюул өсөн нэмэгдсээр байна.

Монгол улсын хүн амын өсөлт болон амьдралын хэв маягийн өөрчлөлт нь улс орны эмзэг экосистемд учрах дарамтыг эрчимжүүлж байна. Бэлчээрийн талхагдал нь улс орны чухал ач холбогдол бүхий бүс нутгийг доройтуулж байгаа бөгөөд зэрлэг ан амьтдыг оршин байгаа нутгаас нь дайжуулж байгаа юм. Үйлдвэр болон хот газраас гарч байгаа бохирдол нь байгаль орчны чанарт сөргөөр нөлөөлж байна. Нөгөөтэйгүүр, байгаль орчны менежмент болон хамгаалах асуудалд учирч буй саад тотгор нь хүний болон санхүүгийн нөөцийн хомсдол болон байгууллагын сул дорой чадавхитай ч холбоотой юм.

Эдгээр бэрхшээлийг давах туулахын тулд Монгол улсын Засгийн газар байгаль орчны багц хуулийг баталж, байгалийн нөөц газрыг өргөжүүлэн, эрчим хүчний үр ашигтай технологийг нэвтрүүлж, бохирдлыг бууруулахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг дэмжиж байна. Стратегийн цаашдын зорилгын үүднээс Засгийн газар 1995 оны Байгаль орчны үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг дахин хянаж үзэн байгаль орчны асуудлыг Хүний аюулгүй байдлыг хангах Сайн Засаглал хөтөлбөрт тусгасан болно.

Монгол улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийг дуусаж байгаа учраас Засгийн газар байгалийн нөөц болон эрүүл орчин нь улс орны хөгжил дэвшилд чухал дэмжлэг үзүүлдэг гэсэн ойлголтыг дэмжих нь чухал юм. Иймд Засгийн газар олон улсын байгууллага, иргэний нийгэмлэг болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Эдгээр санаачилгыг үр дүнтэй хэрэгжүүлэх нь байгаль орчны хандлага болон гол үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийхийг шаарддаг байна. Байгаль орчны энэхүү хяналт- шинжилгээ нь Монгол улсын байгаль орчны гол хандлагыг харуулж байгаа болно. Энэхүү номд орсон мэдээллийг Засгийн газрын байгууллага, их, дээд сургууль болон төрийн бус байгууллагын тайлан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, хоёр талын хандивлагч байгууллагын баримт бичиг болон хүвч хүний хэвлэгдээгүй тайлан зэрэг олон эх үүсвэрээс авсан болно.

Үйлдвэрлэл, хэрэглээ, бохирдол болон хүрээлэн буй орчны гол үзүүлэлтүүдэд байгаль орчны талаас нь үнэлэлт өгөхийг оролдсон юм. Боломжит тоо баримтын цөөн хэдээс үзэхэд Монгол улс байгаль орчны гол хандлагын талаар цаг үеэ олсон баримт цуглуулах чадавхийг бий болгох нь чухал гэдэг нь харагдаж байна. Энэ нь Засгийн газарт Мянганы хөгжлийн зорилгыг үр дүнтэй ажил хэрэг болгоход тустай юм.

Шийдвэр гаргагчдад, энэхүү хяналт- шинжилгээ нь байгаль орчны гол мэдээллийг нэг баримт бичиг болгон өгч, үүнийг бодлого, төлөвлөгөө боловсруулахад онцгой анхаарах нь чухал юм. Эрдэмтэд, судлаачдад энэ нь бэрхшээлтэй асуудлын талаар өргөн мэдээлэл өгөх юм. Иргэний нийгэмд энэ нь бусад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай санал солилцох боломжийг бүрдүүлнэ. Түүнчлэн хандивлагч байгууллагад Монгол улсын байгаль орчны чиглэлээр хамтран ажиллах талаар бэрхшээлтэй болон боломжийг харуулах юм.

Бүхэлдээ, энэхүү хяналт- шинжилгээ нь байгаль орчны өөрчлөлт, маргаантай асуудлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад мэдээлэл өгөх, тэднийг байгаль орчны чиглэлээр ажиллах хүсэл сонирхлыг татахад зориулагдаж байгаа болно. Жил бүр хэвлэгдэж байдаг энэхүү цувралын дараагийн дугаарт сонирхол татахуйц байгаль орчны асуудлыг сонгон тусгах болно.

Товчлол ба хураангуйлал

АХБ	Азийн Хөгжлийн Банк
АЗХӨ	амьсгалын замын хүнд өвчин
АОУХА	Австралийн Олон Улсын Хөгжлийн Агентлаг
БХХ	биохимийн хүчилтөрөгчийн хэрэгцээ
ДЦС	дулааны цахилгаан станц
КОУХА	Канадын Олон Улсын Хөгжлийн Агентлаг
ДОУХА	Данийн Олон Улсын Хөгжлийн Агентлаг
УХ	уусгасан хүчилтөрөгч
БОНУ	байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
БОМТ	байгаль орчны менежментийн төлөвлөгөө
ХХААБ	Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
ДДБОС	Даян дэлхийн байгаль орчны сан
МУЗГ	Монгол улсын Засгийн газар
ГТХАН	Германы Техникийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэг
ЗУЗ	зөвхөн уурын зуух
ОУХСТ	Олон Улсын Хөгжлийн Судалгааны Төв
ЯОУХАБ	Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Банк
ЯОУХАА	Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг
км	километр
м3	шоометр
МҮАХ-21	Монгол улсын 21 дүгээр зууны үйл ажиллагааны хөтөлбөр
мг/м3	нэгж шоометр дэх микрограмм
БОЯ	Байгаль орчны яам
БОҮҮАХ	Байгаль орчны үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр
ТББ	Төрийн бус байгууллага
NO2	азотын давхар хүчил
ҮСГ	Үндэсний Статистикийн газар
ҮАТ	үйл ажиллагаа ба тусламж
SO2	хүхрийн давхар хүчил
НН	Нийт нян
НҮ	Нэгдсэн Үндэстэн
НҮХХ	Нэгдсэн Үндэстний Хөгжлийн Хөтөлбөр
НҮЦГЗТБ	Нэгдсэн Үндэстний Цөлжилт, ган зудтай тэмцэх байгууллага
АНУОУХА	Америкийн Нэгдсэн Улсын Олон Улсын Хөгжлийн Агентлаг
ДБ	Дэлхийн Банк

Жин, хэмжүүр

га	10,000 м2
км2	100 га

Байгаль орчны үзүүлэлт: Хандлага ба шинж тэмдэг

Асуудал	Хандлага	Шалтгаан
<b>Ногоон</b>		
Ойн талбайн хомсдол	<ul style="list-style-type: none"> <li>• 1990- 2000 онд 60,000 га талбай ой устсан;</li> <li>• 1990-2000 онд 7 сая га ой түймэрт нэрвэгдсэн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Буруу бодлого ба түүний хэрэгжилт муу</li> <li>• Ойг тогтвортой ашиглах техникийн болон дэд бүтцийн нөхцөл муу</li> <li>• Түлээний болон модны дотоодын эрэлт нэмэгдэж байгаа</li> </ul>
Биологийн төрөл зүйлийн хомсдол	<ul style="list-style-type: none"> <li>• Таван хошуу мал бэлчээрийг талхалж байна;</li> <li>• Хууль бус агналт/загас барих аялал нэмэгдэж байна;</li> <li>• Эмийн ургамлыг хэт их хэмжээгээр түүж байна</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Газар ашиглалтын өөрчлөлт;</li> <li>• Мод огтлолт;</li> <li>• Агнуур/загас барих асуудлын хангалтгүй журамлалт</li> </ul>
Газрын доройтол	<ul style="list-style-type: none"> <li>• Нийт бэлчээрийн газар нутгийн 5-9 хувь нь одоогийн байдлаар доройтолд ороод байна</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Газар ашиглалтын зохисгүй байдал;</li> <li>• Байгалийн гамшиг (зуд, ган, хээрийн түймэр)</li> </ul>
<b>Хөх</b>		
Усны хэрэгцээ хангамжаасаа илүү байдаг	<ul style="list-style-type: none"> <li>• Туул, Хараа, Хэрлэн голуудын усны түвшин багасч байна;</li> <li>• Гүний усны түвшин буурч байна</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Усны зохисгүй үнэ</li> <li>• Дэд бүтэц муу</li> <li>• Хотжилт (хотын төвлөрөл)</li> </ul>
<b>Хүрэн</b>		
Улаанбаатар хот болон бусад суурин газруудын агаарын бохирдлын ихсэлт	<ul style="list-style-type: none"> <li>• Сүүлийн 10 жилд цахилгаан станц, уурын зуух болон автомашинаас ялгарч буй SO<sub>2</sub> болон NO<sub>2</sub> бодисуудын хэмжээ тогтмол өссөөр байна;</li> <li>• Амьсгалын замаар өвчилж буй таваас доош насны хүүхдүүдийн тоо өсөж байна</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Аж үйлдвэр</li> <li>• Цахилгаан станц ба уурын зуух</li> <li>• Тээвэр</li> <li>• Тоос</li> <li>• Хог шатаалт</li> </ul>

Томоохон голуудын усны чанарын муудалт	<ul style="list-style-type: none"> <li>Хортой болон аюултай хог хаягдлын хэмжээ ихсэж байна</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Үйлдвэрлэлийн хаягдал</li> <li>Дотоодын бохир ус</li> <li>Хатуу хог хаягдал</li> </ul>
Хатуу болон аюултай хог хаягдлын үйлдвэрлэлийн өсөлт болон зохисгүй менежмент	<ul style="list-style-type: none"> <li>Сүүлийн 10 жилд хатуу хог хаягдлын хэмжээ өсөж байна;</li> <li>Ил хогийн цэг болон хогийг шатаах үйл ажиллагаа үргэлжилж байна;</li> <li>Хортой болон аюултай хог хаягдлын хэмжээ өссөөр байна</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хотжилт</li> <li>Хатуу хог хаягдлын нэгдсэн менежментийн тогтолцоо байхгүй</li> <li>Олон нийтийн сурталчилгаа хязгаарлагдмал</li> <li>Хортой болон аюултай хог хаягдлын үйлдвэрлэл байхгүй</li> </ul>

Энэхүү үзүүлэлт нь Монгол улсын байгаль орчны гол шинжийг гаргах гэсэн анхны оролдлогыг харуулж байна. Үзүүлэлтийн сонголт үнэн тоо баримтад тулгуурласан болно. Энд сонгогдсон үзүүлэлт нь үйлдвэрлэл/хэрэглээ болон чанарын хүчин зүйлийг харуулж байна. Хүрэн, Ногоон болон Хөх үзүүлэлт гэж ангилсан болно.

#### Байгаль орчны үзүүлэлт: Хандлага ба шинж тэмдэг

Асуудал	Хандлага	Шалтгаан
<b>Ногоон</b>		
Мод бэлтгэлийн жилийн хэмжээ	0.3 хувь	1900-2000
Арилжааны модны жилийн дундаж алдагдал	4-6 хувь	1990-2000
Түймэрт нэрвэгдсэн модны талбай	7.1 сая га	1990-2000
Хээрийн түймэрт нэрвэгдсэн бэлчээрийн талбай	41.4 сая га	1990-2000
Малын тоо	30 сая толгой	2000
<b>Хөх</b>		
Ундны аюулгүй усаар хангагдаж буй хүн амын эзлэх хувь	Нийт хүн амын 60 хувь Хотын хүн амын 77 хувь Хөдөөгийн хүн амын 33 хувь	2000
<b>Хүрэн</b>		
NO <sub>2</sub> -ийн түвшин	Жилийн дундаж агууламжийн хэмжээ 14-өөс 25.5 мг/м <sup>3</sup> хүртэл өсөж байна	1994-2000
SO <sub>2</sub> -ийн түвшин	Жилийн дундаж агууламжийн хэмжээ 4-өөс 9 мг/м <sup>3</sup> хүртэл өсөж байна	1994-2000
Тоос	Жилийн дундаж агууламж 137 мг/м <sup>3</sup>	1994-2000




Нүүрсний жилийн дундаж хэрэглээ /эрчим хүчний үйлдвэрлэл, халаалт болон хоол хийх зориулалтаар/	5.7 сая тонн	1999-2002
Ариун цэврийн байдалд нийт хүн амын эзлэх хувь	Нийт хүн амын 25 хувь Хотын хүн амын 46 хувь Хөдөөгийн хүн амын 2 хувь	2000
Хатуу хог хаягдлын менежментээс үр шимийг нь хүртэх хүн амын эзлэх хувь	40 хувь	1980-2000


*Хурэн үзүүлэлт* нь үйлдвэр, хот суурин газар, тээвэр болон эрчим хүчний эх үүсвэрээс гарч буй бохирдол болон тэдгээрийн нэг болон хамтын үзүүлж буй нөлөө, хамгаалах арга хэмжээнд хэрэглэдэг түгээмэл нэр томъёо болно. *Ногоон үзүүлэлт* нь хөдөө аж ахуй, мод бэлтгэх, газар ашиглалтын өөрчлөлт болон хуулиар хамгаалагдсан амьтан, ургамлыг устгах болон тэдгээрийг хамгаалах арга хэмжээнээс үүдэн гарч буй байгаль орчны нөлөөг үзүүлж байгаа юм. *Хөх үзүүлэлт* нь усны нөөцийн менежменттэй холбоотой. *Байгаль орчны үзүүлэлт* нь байгаль орчны чанарт гарах аливаа өөрчлөлтийг тэмдэглэх үндэс суурь болох юм.

## Ногоон үзүүлэлт Ой

Монгол орны нийт газар нутгийн 11 хувь буюу 18.3 сая га газрыг ой бүхий талбай эзэлдэг байна. Сибирийн тайгын үргэлжлэл болох шилмүүст ой нь нутгийн төв-хойд уулыг бүрхдэг. Нутгийн өмнөд болон баруун-өмнөд хэсэгт байх цөлд заган ой ургана. Ой нь газрыг элэгдэл болон цөлжилтөөс хамгаалж, малын тэжээл болон түлшний модоор хангадаг юм.



Сүүлийн жилүүдэд, Монгол орон жилд дунджаар 40,000 га ойролцоогоор нийт 4 сая га ой устаж үгүй болсон байна. 1990-2000 онд мод бэлтгэлийн хэмжээ жилд 60,000 га хүртэл нэмэгдсэн бөгөөд эдгээр нь худалдааны зориулалтаар бэлтгэгдсэн болно. Мод бэлтгэлийн энэ үр дүнд хот, суурин газраас алс зайд орших зөвхөн 13 сая га талбай үлдэж хоцорсон байна. Үлдсэн 5.3 сая га талбай ой устсан байна.



Удаан хугацаанд үргэлжлэх Монгол орны хуурай уур амьсгал нь ойг хойт тал руугаа аажмаар нүүхэд нөлөөлж байна. Гэхдээ өнөө үед ой хурдацтай устаж байгаа явдал нь гол төлөв ойн түймэр, зүй бус арилжаа болон хууль бус мод бэлтгэл, ойн хууль тогтоомжийн хангалтгүй мөрдөлт, мал болон ойн хортон, хөнөөлт шавьжид залуу мод идэгдэж байгаатай холбоотой юм.

Ойн нөөц төрийн өмч бөгөөд түүнийг ашиглах эрхийг бусдад шилжүүлж болно. Үйлдвэрлэлийн зориулалтаар модыг Монгол оронд 30-40 жилийн өмнөөс хавтгайруулан огтолж эхэлсэн бөгөөд өнөө үед үүнийг хориглосон болно. Одоогоор, нэг сая га гаруй талбайг бэлтгэнэ гэж тогтоосон боловч үүний нэгээс бага хувь нь хамтын эзэмшлийн ойд хамаарагдаж байна.

## Ногоон үзүүлэлт Ой

Зах зээлийн харилцаанд шилжиж эхэлсэн 1990-ээд оны дунд үеэс модны үйлдвэрлэл багагүй бэрхшээлтэй тулгарч байна. Тухайлбал, хөрөнгө оруулалтын дутагдал, хангалтгүй бэлтгэгдсэн ажиллах хүчин, хуучирсан тоног төхөөрөмж, болон байгууллагуудын тодорхойгүй хариуцлага зэрэг болно. Шилжилтээс өмнө ойролцоогоор 2.2 сая шоометр мод жилд бэлтгэгддэг байсан юм. Модны үйлдвэрлэл ДНБ (дотоодын нийт бүтээгдэхүүн)-ний 6 хувийг үйлдвэрлэдэг бөгөөд 20,000 хүнийг ажлын байраар хангадаг болно.

Өнөөгийн модны үйлдвэрлэлийн жилийн дундаж эзэлхүүн 0.5 сая шоометр бөгөөд ДНБ-ний нэгээс доошгүй хувийг үйлдвэрлэж байна. Одоогийн байдлаар, 3,000 хүрэхгүй ажилчид байгаа бөгөөд ихэнх нь Сэлэнгэ аймгийн<sup>1</sup> жижиг үйлдвэрүүдэд ажиллаж байна. Мод бэлтгэлийн үйлдвэрлэлийг залуужуулах бодит хөшүүрэг одоо болтол үгүйлэгдсээр байгаа бөгөөд банкны зээлийн өндөр хүүгээс шалтгаалан хөрөнгө оруулалт саатаж байна.

Ой багасч байгаагийн нэг шалтгаан нь модыг дулаацуулах болон хоол хийх зориулалтаар нутгийн хойд хэсгээс бэлтгэдэгт оршино.

Дулааны болон ахуйн зориулалтаар ашиглах модны хэмжээ 1.5 сая шоометр гэж тооцоологдсон байна. Эдгээр зориулалтын нэрийн дор модыг хууль бусаар огтлох явдал олширч байна. Хэдийгээр Хятад улс руу хулгайгаар бэлтгэгдсэн мод гардаг тухай албан ёсны мэдээлэл байдаг боловч энэ талаархи тодорхой тоо баримт байдаггүй юм.

## Ойн болон хээрийн түймэр

Чийг багатай, хуурай уур амьсгал болон хүчтэй салхи бүхий хуурай улиралтай Азийн орнуудаас Монгол орныг түймэрт ихээр өртөмтгий орнуудын нэг болгодог байна. Улсын нийт нутаг дэвсгэрийн талаас илүү хувийг түймрийн эрсдэлтэй бүс нутаг гэж үздэг бөгөөд ой мод бүхий талбайн 98.5 хувь нь түймрийн өндөр эрсдэлтэй бүс нутагт хамрагддаг байна. Түймэр гарах магадлал 3 дугаар сараас 5 дугаар сар хүртэл болон 9 дүгээр сараас 11 дүгээр сар хүртэл тус тус эрс нэмэгддэг бөгөөд түймрийн нийт 60-аас дээш хувь жил бүрийн 4-5 дугаар сард гардаг байна. Хэдийгээр зарим үед эдгээр түймэр байгалиас өөрөөс нь гаралтай байдаг боловч ихэнх тохиолдолд хяналтгүй анчдын отгууд түймэр алддаг байна. Сүүлийн 10 жилд 1,833 ой, хээрийн түймэр гарсан нь тогтоогджээ. Энэ нь 41.1 сая га бэлчээрийн талбай, 7.1 сая га ой бүхий талбайг хамарсан байна. Зөвхөн 1996 он гэхэд 417 түймэр гарсан нь сүүлийн жилүүдэд тохиолдоогүй хамгийн их түймэр гарсан жил байсан бөгөөд эдгээр түймрийн хохирол нь 1.13 тэрбум төгрөгт хүрсэн байна. Монголын цаг агаар хахир хүйтэн, хуурай байдаг учир мод ургах тааламжтай нөхцөл богино байдаг. Иймд, байгалийн ийм гамшгийн дараа мод дахин сэргэж ургахад ой мод 200-аас илүү жил шаардагддаг байна.

Шилжилтээс өмнө, иргэний хамгаалалтын салбар бэлтгэгдсэн боловсон хүчин болон агаарын эргүүл гарган түймрээс урьдчилан сэргийлдэг байсан байна. Өнөөдөр Монгол улсын Засгийн газар түймрээс урьдчилан сэргийлэхийн тулд боловсрол (сургалт), сургалчилгаа явуулж хяналт тавин түүнийг унтраах замаар түймрийн нэгдсэн менежментийг дэмжиж байна. Энэхүү чармайлт орон нутгийн түвшинд иймэрхүү хандлагын үр дүнг харуулж үндэсний түвшинд

<sup>1</sup> “Аймаг” гэдэг нь улсын хамгийн том дэд засаг захиргааны нэгж юм. Монгол улс 21 аймагтай. Монгол улсын талаархи товч мэдээллийг үзнэ үү.

Ногоон үзүүлэлт  
Ой

хангалттай нөөцийг бэхжүүлж байна. Монгол улс, Япон улсын хамтран хэрэгжүүлж буй төсөл болох Хэнтий аймаг, түүнчлэн Улаанбаатар хотоос гадагш мод үржүүлгийн газар байгуулж байгаа нь БОЯ-нд түймэрт нэрвэгдсэн талбайг нөхөн сэргээхэд дэмжлэг үзүүлж байгаа юм.

## Ногоон үзүүлэлт Ойн бодлогын хэрэгжилт

1990 оноос хойш ойн салбарын бүтэц болон хууль эрх зүй байнга өөрчлөгдсөөр байна. Ойн тухай хууль, Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн тухай хууль, Ойн үндэсний бодлого болон Ойн үндэсний хөтөлбөр нь ойн нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах хууль эрх зүйн үндэс болдог. Түүнчлэн ой модны үйлдвэрлэлийг нөхөн сэргээх болон модны аж ахуйг дэмжих зорилгоор Ойн үндэсний хороо 2001 онд байгуулагдсан болно.

Засгийн газар 30 жилд мод тарих хөтөлбөртэй байв. Ойжуулсан талбайн нийт хэмжээ нийт алдагдсан ойн талбайн зөвхөн 5 хувийг нөхөж байна. Энэ нь тарьцын ургах чадвар муутай холбоотой юм. Одоогоор нийт 150,000 га ойг нөхөн сэргээх шаардлагатай байгаа бөгөөд жил бүр зөвхөн 5,000 га ойг нөхөн сэргээж байна.

## Ногоон үзүүлэлт Биологийн төрөл зүйл

Монгол<sup>2</sup> улсын Дагуурын тал хээр нутаг, Алтай- Саяны уул нь дэлхийн биологийн хоёр “экобүс”-т хамрагддаг газрууд юм. Шилмүүст ой болон өргөн уудам байгаль нь биогазарзүйг Сибирь болон Төв Азийн говь цөл болгон хуваадаг бөгөөд амьтан, ургамлын биологийн төрөл зүйлийн төв юм.

Биологийн арвин төрөл зүйл нь Хойд болон Өмнөд Азийн амьтан, ургамлын хослолын үр дүн юм. Монгол улс 2,823 гаруй ургамлын зүйлийн өлгий нутаг юм (Төв Сибирт 2,400; Өвөр Монголд<sup>3</sup> 2,176 харьцуулахад). Түүнчлэн энэ нь одоо устаж буй болон ховордож буй ирвэс, тахь, илжиг, аргаль, янгир, мазаалай, хавтгай, бөхөн гөрөөсний уугуул нутаг болно. Монголд загасны хамгийн эмгэнэлт зүйл бол онцгой ер бусын зэрлэг тул загас юм. Энэ нь дэлхийд хамгийн том яргай загас бөгөөд Орост мөхөж буй загасны зүйл билээ.

Олон амьтан, ургамлыг дотоодын хэрэгцээнд ашиглахын зэрэгцээ экспортолдог байна. Ургамлыг эмчилгээний (... бамбай, .. г.м.) болон түлшинд (заг, тоорой, сухай г.м.) хэрэглэдэг. Амьтдыг ангийн мах болон тэдгээрийн үс (булга, үнэг, ирвэс, тарвага)-ийг ашиглах зорилгоор агнадаг байна. Бугын эврийг Хятадын уламжлалт анагаах ухаанд ашигласаар ирсэн юм.

Монголын биологийн төрөл зүйл томоохон аюул заналтай тулгардаг байна. Ургамал, амьтны хэт ашиглалт болон түүх нь тэдгээрийн гол аюул мөн. Ой, хээрийн түймэр нь ан амьтныг устгаж тэдгээрийн амьдрах газар нутгийн талбайг багасгадаг. Таван хошуу мал бэлчээрийн талбайд дарамт учруулснаар хөрсний төрөл зүйл, үржил шим, тэжээллэг чанарыг бууруулж байна. Уур амьсгалын өөрчлөлт хөрсний температур, чийг, ургамалд нөлөөлснөөр зүйлийн тархцалд сөргөөр нөлөөлж байгаа юм.

Манай нутгийн онгон байгаль, ан амьтан гадаадын жуулчдын сонирхлыг ихээр татаж байгаагаас аялал жуулчлал улам хүчээ авсаар байна. 1997 онд аялал жуулчлалын салбар гадаадаас орж буй ашиг орлогын 5-10 хувийг олж байв. Учир нь нийт жуулчдын тоо харьцангуй бага байгаа бөгөөд байгаль орчны нөлөө хязгаарлагдаж байгаатай холбоотой юм (Хархорин, Горхи Тэрэлжийн байгалийн цогцолборт газар, Говь Гурвансайханы Дархан цаазат газарын Ёлын Ам хавцал хамаарахгүйгээр). Хатуу хог хаягдлын үйлдвэрлэл, усны нөөцийн хэт ашиглалт, ариун цэврийг сахихгүй байх явдал болон хөрсний гадаргуугийн бохирдол нь эдгээр тусгай хамгаалалттай газар нутгийг бохирдуулах үндсэн шалтгаан болж байгаа юм.

## Монгол улсын ан агнуур

### Ахуйн хэрэгцээний ан агнуур

Орчин үеийн судалгаагаар ахуйн хэрэгцээний зориулалтаар ядуу малчид (50 хувь)-тай харьцуулахад баячууд (60 хувь) илүүтэйгээр ан хийдэг болох нь тогтоогдсон байна. Гэхдээ баячууд ядуу малчдын агналтад зарцуулж буй цаг хугацааны гуравны нэг хувийг эзэлж байгаа юм. Ан амьтны нөөцийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Монгол улсын Засгийн газар малчдаас ангийн лиценз худалдан авахыг шаардаж байгаа юм. Энэхүү лицензэд жилд агнах ангийн тоо толгойг заадаг болно. 1995 оноос худалдагдаж буй лицензийн тоо өссөөр байна. Ихэнх малчид лицензэд заасан тоог багасган хэлж башир арга хэрэглэж байгаагаас лицензэд заасан агнах ангийн дундаж тоо буурч байна. Үүний учир нь лицензийн үнэ их тогтворгүй байдаг зах зээлийн үнийн 20 хувийг бүрдүүлдэг

<sup>2</sup> Дэлхийн Байгаль хамгаалах сан, Ховордсон амьтан, ургамлын төрөл зүйл- Даян дэлхийн 200 экобүс (2000).

<sup>3</sup> Гунин, Монгол орны ургамлын динамик; Клувер, Амстердам (1990).

бөгөөд энэ нь анчдыг лиценз худалдан авах сонирхлыг төрүүлдэггүй байна. Зүүн аймгууд 2001 онд лиценз худалдан олж болох 42 сая төгрөгийг алдсан байна.

### Ангийн жуулчлал

Сүүлийн 10 жилд ангийн жуулчлал хүчээ авсаар байна. Учир нь түүний ан амьтанд үзүүлж буй нөлөө одоогоор тодорхойгүй байгаа тул ангийн энэ хэлбэр маргаантай юм. Ангийн жуулчлал мөн лиценз худалдан авахыг шаарддаг байна. Агнах ангийн зүйлээс шалтгаалан лицензийн үнэ янз бүр байна. Аргаль хонины хэмжээ, түүний амьдрах нутгаас шалтгаалан ангийн лицензийн үнэ 20-30 мянган ам. доллар, зээр 10-15 мянган ам. доллар, шонхор шувуу 4,5 мянган ам. доллар, буга 3,5 мянган ам. доллар, хүрэн баавгай 2,5 мянган ам. доллар, ирвэс 2 мянган ам. доллар, янгир болон буга 1,0 мянган ам. доллар байдаг байна.

Зохицуулалттай ангийн жуулчлалын лицензийн орлогоос 1997 онд 3 сая ам. доллар олж байв. Хуулийн дагуу орлогын 70 хувь улсын төвлөрсөн төсөвт, 20 хувь нь орон нутгийн төсөвт, 10 хувь нь ангийн компанид ордог байна. Гэвч амьдрал дээр орлогын 75-аас илүү хувь ангийн компанид үлдэж, орлогын зөвхөн 10 хувь нь Байгаль орчны яам болон орон нутгийн төсөвт ордог байна.

**Ногоон үзүүлэлт**  
**Биологийн төрөл зүйлийн бодлогын**  
**хэрэгжилт**


Дэлхийн биологийн өвийн эдийн засгийн нөөц болон Монголын болон бусад ард түмэнд оюуны цэнгэлийн эх үүсвэр нь болдог учир Монгол улсын Засгийн газар биологийн төрөл зүйлийн ач холбогдлыг өндрөөр үнэлдэг байна. Түүхийн он жилүүдэд Монголын ард түмэнд онцгой гэж үздэг газар болон зүйлийг хамгаалан иржээ.

Улаанбаатар хотын өмнө зүгт байрлах Богдхан уул нь 1778 онд дархлагдсан байна. Засгийн газар нийт нутаг дэвсгэрийн 13 хувь буюу 20 сая га газар нутгийг эзлэх 48 тусгай хамгаалалттай газар нутаг (ТХГН)-ийг хамгаалалтад аваад байна. Түүнчлэн орон нутгийн засаг захиргаад 1 сая га талбай бүхий 115 газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад аваад байгаа юм.

Хэдийгээр Монгол улсын ТХГН-ийн талбай олон улсын нормоос хэтэрч байгаа ч Монгол улсын Засгийн газар ТХГН-ийн сүлжээг нийт нутаг дэвсгэрийн 30 хувь хүртэл нэмэхээр төлөвлөж байна.

Монгол орны зүүн хэсэгт орших зээрийг их хэмжээгээр арилжааны зорилгоор агнаж байгаа нь хууль бус хэмээн зарлаж байгаа хэдий ч ахуйн зорилгоор зээрийг агнуулсаар байна. Барьж буцаан тавих менежментэд суурилсан байгалийн тогтвортой аялал жуулчлал Хөвсгөл нуурын дэргэд хөгжиж байна. Хөвсгөл нуур тул загасны арвин нөөцтэй юм.

Биологийн төрөл зүйлийг хамгаалахтай холбогдсон Монгол улсын хууль тогтоомжууд бий. 1996 онд Монгол улсын Засгийн газар Биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, Ховордсон амьтан, ургамлын төрөл зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцид нэгдэн орсон болно.



Эх үүсвэр: Байгаль орчны яам, Улаанбаатар, 2002 оны 3 дугаар сар

**Байгалийн нөөцийн Буддагийн шагнал**

Дэлхийн Байгаль хамгаалах сангаас хэрэгжүүлж буй хөтөлбөрийн нэг болох “Эх дэлхийдээ барих ариун бэлэг”, Дэлхийн Байгаль хамгаалах сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар Буддын шашны газартай хамтран Буддын сургааль (ном) заах ажлыг дэмжин ажиллаж ирлээ. Монголын бэлэг нь Буддын ариун газарт ан хийх болон мод бэлтгэхийг олон зуун жил хориглож ирсэн хуучин (уламжлалт) хууль журамд эргэж оруулах явдал юм. Буддагийн уламжлалт төрсөн өдөр буюу 2000 оны 5 дугаар сард Монгол улсын тэргүүн хамба лам энэ тухай улс орны 140 гаруй хийдэд зарласан байна.



Ногоон үзүүлэлт  
Биологийн төрөл зүйлийн бодлогын  
хэрэгжилт

Монгол улсад Буддагийн ариун дагшин уул, ой, мод болон булаг шандыг оролцуулаад 600 гаруй ариун газар бий гэж тогтоогдсон байдаг. Энэхүү хориг нь бүхий л амьдралын туршид өрөвдөн энэрэх байгалийн нөөцийн тогтвортой менежментийг дээдэлдэг эртний Буддагийн номлолын илэрхийлэл юм. Буддагийн нөөц газар байгуулах болон мод бэлтгэх, ан гөрөө хийхэд хориг тавих явдлыг дахин сэргээх нь байгаль орчныг хамгаалахад хүчтэй ёс суртахууны болон шашны дэмжлэг үзүүлнэ хэмээн горьдлого тавьж байгаа болно.

*Эх үүсвэр: Байгаль орчны яам, Улаанбаатар, 2002 оны 3 дугаар сар*

## Ногоон үзүүлэлт Газар

Монгол улс 1.56 сая хавтгай дөрвөлжин км нутагтай билээ. Хүн амын өсөлтөөс шалтгаалан нэг хүнд ногдох газар нутгийн дундаж талбай 1919 онд 2.42 хавтгай дөрвөлжин км-ээс 1997 онд 0.64 хавтгай дөрвөлжин км болтлоо багасаж байна. Ойролцоогоор нийт нутаг дэвсгэрийн 82 хувийг бэлчээрийн талбай эзэлдэг бөгөөд энэ нь дэлхийд хамгийн том бэлчээрийн талбай юм. Энэхүү бэлчээрийн талбай нь цөл- хээрийн болон ой/уулын хээрийн экосистемийн өргөн хүрээг хамардаг.



Ерөнхийдөө, газрын доройтлыг “хүмүүсийн үйл ажиллагааны үр днгээс ихэнхдээ үүдэн гардаг газрын чанарын өөрчлөлт” хэмээн тодорхойлдог. Газрын доройтлын зэрэг, түүний хир хэмжээнээс шалтгаалан янз бүр байна. Газрын доройтлыг байгууллага бүр янз бүрээр тодорхойлдогос Монгол улсад газрын доройтолд орсон газрын хэмжээ янз бүр байдаг байна. Монгол улсын Газрын хэрэг эрхлэх газрын хийсэн судалгаагаар бэлчээрийн талбайн 9 хувь газрын доройтолд ямар нэг хэмжээгээр өртсөн гэсэн баримт бий. 2002 оны Байгаль орчны үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрт бэлчээрийн газар нутгийн 7 хувь “хүчтэй доройтолд орсон”, 70 хувь нь “доройтсон” гэж дурьдсан байна. 21 дүгээр зууны Монголын үйл ажиллагааны хөтөлбөр (МАР-21)-т 1998 оны байдлаар бэлчээрийн газар нутгийн 5-9 хувь “хүчтэй доройтож байна”, 30 хувь нь “эвдрэлд орсон” гэж дүгнэгдсэн байна. Нийт газар нутгийн 78 хувь “доройтсон” гэсэн судалгаа бий.

## Ногоон үзүүлэлт Газар

Бэлчээрийн хуурай экосистемд малын тоо толгойн нягтрал ургамлын нөхцөлтэй ойр нийлж “тэнцвэр”-тэй байдаг. Гэвч, Монголыг оруулаад дэлхийн бэлчээрийн хуурай экосистемийн ихэнх нь “тэнцвэртэй” байдаггүй. Эдгээр бүс нутагт ургамлын нөхцөл нь малын бэлчээрийн нягтралыг бодвол хур тунадаснаас илүүтэйгээр шалтгаалдаг байна.

Монголын бүх бэлчээр хуурай болон хагас- хуурай нутагт хамрагддаг бөгөөд хур тунадасны жилийн дундаж итгэлцүүр уулархаг- тал бүсэд хур тунадас 28 хувиас говь- цөлийн бүсэд<sup>4</sup> 50 хувь хүртэл хэлбэлздэг байна.

33 хувиас илүү хур тунадасны итгэлцүүртэй байдаг бүс нутагт ургамлын нөхцөл бэлчээрийн шахалтын нөлөөг бодвол хур тунадасны хэмжээнээс илүүтэйгээр хамаардаг байна. Чийглэг уул хээрийн бүсэд малын тоо толгойн нягтрал ургамалд сөргөөр нөлөөдөг болох нь тогтоогджээ. Өөр бусад газарт малын тоо толгойн нягтрал, ургамлын нөхцөл хоёрын учир шалтгааны холбоог тогтооход бэрх юм. Түүнчлэн, бэлчээрийн улирал, бэлчээрийн газрын өсөн нэмэгдэж буй дарамт болон ой/уулын хээрийн бөглөрөлтийн хоорондох хангалтгүй цаг хугацаа нь газрын доройтлыг эрчимжүүлэгч хүчин зүйл болдог байна.

Цөлжилтийг “ур амьсгалын өөрчлөлт болон хүний үйл ажиллагаанаас үүдсэн хуурай, хагас- хуурай болон хуурай чийг багатай газрын доройтол” гэж үздэг. Монгол орны газар нутгийн 41 хувийг Говь хэмээн тодорхойлдог: маш тарчиг бутлаг ургамалтай чулуулаг говь нутаг юм. Энэ нь MAP-21-г тодорхойлогдсоноор нийт газар нутгийн ихэнх нь “эвдрэлд орсон” боловч говьд үндсэн үйлдвэрлэл хүний хэрэглээнээс тусгаар байдаг байна. Элсээр бүрхэгдсэн Монголын газар нутгийн талбай сүүлийн 40 жилд тогтвортой байгаа бөгөөд зөвхөн 0.02 хувиар өссөн байна. Хэрэв цөлжилтийг ийм нарийн утгаар ойлговол Монгол оронд цөлжсөн талбай их хязгаарлагдмал байна.

### Ард иргэдэд түшиглэсэн бэлчээрийн менежмент

2000 оны 8 дугаар сараас 2002 оны 2 дугаар сарын хооронд орон нутгийн ТББ болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр малчдаар бэлчээрийн менежментэд шинэ хадлага нэвтрүүлэх жижиг төсөл хэрэгжүүлсэн болно. Төслийн хүрээнд хүн амын тоо болон зах зээлд хүрэх боломж нь өөр өөр, түүнчлэн экологийн ялгаатай бүс бүхий гурван газрыг сонгосон юм.

Төслийн үзэл баримтлал дараахь таамнал дээр суурилсан болно. Үүнд: малчид тэдний амьдралд хойшлуулшгүй зүйл гарах зэрэг үйл ажиллагаан дээр хамтран ажиллах хүсэлтэй байдаг учир тэд бэлчээрийн менежментэд илүү хамтран ажиллах сонирхолтой байдаг байна. Тухайлбал, мал эмнэлгийн үйлчилгээний хангамж, мал төллөлт, малын нэмэлт тэжээл бэлтгэх болон худалдан авах, малын бүтээгдэхүүнийг борлуулах болон боловсруулах ажлууд хамаарагдана. Эдгээр таамналын дагуу төсөл нь харилцан дэмжлэг үзүүлдэг бүс нутагт гадны дэмжлэг үзүүлсэн юм. Энэ нь ердийн оршин суух болон улирлын

<sup>4</sup> Уул- хээрийн бүсэд жилд дунджаар 250 мм хур тунадас ордог. Харин цөл- хээрийн бүсэд 100 мм, түүнээс бага хур тунадас ордог байна.

<sup>5</sup> Цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааны хөтөлбөр, НҮ-ний Цөлжилттэй тэмцэх конвенц, Женев 1977.

нүүдлийн хэв маяг дээр суурилсан 20 гаруй өрх айл бүхий малчдад аж төрөх ёсны чадавхийг бэхжүүлэхэд туслалцаа үзүүлсэн болно. Эдгээр малчдад бизнесийн болон зохион байгуулалтын чиглэлээр сургалт зохион байгуулав. Түүнчлэн төслийн хүрээнд малчдад чухал хэрэгцээтэй малын эм тариа болон тэжээл худалдан авах, сайн чанарын хээлтүүлэгч авах зэрэгт туслалцаа үзүүлэх санг бий болгосон байна. Мөн орон нутгийн засаг захиргаа, малчид хоёрыг хооронд нь холбоотой байлгах үүднээс үйлчилгээ үзүүлсэн болно. Газрын тухай хуулийн дагуу илүү хамгаалахад чиглэсэн, нийтийн бэлчээр ашиглалтыг дэмжсэн бэлчээрийн газрыг “эзэмших гэрээ” хийхэд тэдэнд мөн туслалцаа үзүүлсэн байна.

Энэхүү төслийн хүрээнд нэвтрүүлсэн малчдын аж төрөх ёсны шинэчлэлийн урт хугацааны нөлөөнд дүгнэлт хийхэд дэндүү эрт байгаа учир Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк болон Нидерландын Вант улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй шинэ хөтөлбөрүүдийн хүрээнд энэхүү туршилтыг дахин турших, төслийг өргөтгөх зорилт тавьж байна.

*Эх үүсвэр: Монгол улсын үйл ажиллагааны хөтөлбөр- 21 хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх: Уламжлалт мал маллагааг сайжруулах, Улаанбаатар: Бодлогын судалгааны төв, 2002*

## Ногоон үзүүлэлт Газрын бодлогын хэрэгжилт

Үндсэн болон Иргэний хуулиуд нь Монгол<sup>6</sup> орны газрын хууль тогтоомжийн хууль эрх зүйн үндэс болно. 1995 онд батлагдсан Газрын хууль нь газрын тодорхой категори дээр аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших 4 төрлийг заасан байна. Эдгээр нь “өмчлөх”, “эзэмших”, “ашиглах” болон “хязгаарлалттай ашиглах” эрх юм. Бэлчээр нь “нийтийн талбай” болон хамгаалагдсан бөгөөд хувийн өмчид хамаарагдахгүй болно. Эзэмших эрхийг анхны удаад 60 жилээр, дахин 40 жилээр сунгаж эрхийг зөвхөн өв дамжуулан шилжүүлнэ. Ашиглах эрх нь хоёрдогч эрх бөгөөд эзэмших эрхтэй боловч гуравдагч этгээдэд шилжүүлж үл болох юм. Хэдийгээр хуулиар газар өмчлөх тухай заасан байдаг боловч одоогоор энэ тухай хууль эрх зүйн механизм нэвтрээгүй байна.

1999-2000 онд орон нутгийн засаг захиргаа өвөлжөөг малчин айл өрхөд 25-аас 40 жилийн хугацаатай эзэмших гэрээ хийсний дагуу хуваарилж өгсөн байна. Зарчмын хувьд, бэлчээрийн менежментийн хууль эрх зүйн хүрээ бэлчээрийн нүүдлийн мал аж ахуйг дэмжиж, бэлчээрийн нүүдлийн уламжлалт байдлыг хангадаг байна. Амьдрал дээр, хүн ам, эдийн засаг, нийгмийн өөрчлөлт нь нүүдэл болон бэлчээрийн сэлгээг бууруулах хандлага гарч байгаа бөгөөд Газрын тухай хуулийг хэрэгжүүлэхэд орон нутгийн засаг захиргааны зүгээс харьцангуй бага дэвшил гарч байна.

Газрын тухай хуульд оруулах гэж буй нэмэлт, өөрчлөлт нь бэлчээрийг эзэмших эрхийг малчдын тодорхой бүлэг хүмүүст шилжүүлэх боломжийг алдагдуулж болох юм. Энэ нь бэлчээрийг нээлттэй- хүрэх нөөц болгон улмаар малчдыг өөрсдийнхөө бэлчээрийг зохицуулах хяналттай- хүрэх өмч болгох бүрэн эрх эдлэх боломжийг сулруулах юм.

1995 онд батлагдсан “Газрын төлбөрийн тухай” хууль нь байгалийн бүс болон хөрсний чанарын ангилал дээр үндэслэн газар эзэмших, түүнийг ашиглах төлбөрийг тогтоосон байна. Газрыг хамгаалах сан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас цуглуулсан газар ашиглах төлбөрөөс бүрдэнэ. Газар ашиглах төлбөрийн орлогын 30 хүртэлх хувь газрыг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулагдана. Газрын доройтол болон хөрсний элэгдлийг бууруулах чиглэлээр ажиллаж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь газар ашиглалтын төлбөрөөс чөлөөлөгдөнө. Газрын хэрэг эрхлэх газар (хуучнаар Газар зохион байгуулалтын алба) 1997 онд байгуулагдсан болно. 2000 онд “Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө” экологийн тогтвортой газрын менежментийг дэмжихэд чиглэн боловсруулагдсан болно. Засгийн газрын 2001 оны 3 дугаар сарын 47 тоот тогтоол нь бэлчээрийн эрсдэлийн менежментийн хүрээг тодорхойлж, малчид болон орон нутгийн засаг захиргаад эрсдэлд бэлтгэх, түүний нөлөөг сайтар зохицуулахад чиглэгдсэн байна.

Монгол улс 1996 онд Цөлжилттэй тэмцэх НҮ-ний конвенцид гишүүнээр нэгдэн элссэн бөгөөд Цөлжилттэй тэмцэх үндэсний төлөвлөгөөг боловсруулсан билээ. Бэлчээрийн талхагдал, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах болон бэлчээрийн хөнөөлт шавьж, мэрэгч амьтадтай тэмцэх асуудлууд нь уг төлөвлөгөөний үндсэн тусгагдахуун болсон байна. Байгаль орчны үндэсний үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу газрыг хамгаалах, нөхөн сэргээх хуулийн өнөөгийн хэрэгжилт хангалттай биш бөгөөд бүхий л засаг захиргааны

<sup>6</sup> Ханштад Т., Дункан Ж. *Монгол улсын Газрын шинэчлэл: Судалгаа болон санал*. Хөдөөгийн хөгжлийн хүрээлэн, Гадаадын тусламж ба хөгжлийн тайлан, №109, Сизтл, АНУ, 2001



түвшинд газрын менежмент хийдэг байгууллагуудыг бэхжүүлэх шаардлагатай байна.

Асуудал  
1999-2000 оны ахуй амьдрал болон малын  
тоо толгойн өөрчлөлт

Зах зээлийн эдийн засгийн шилжилтийн үед буюу ахуй амьдралын боломж муу үед ихэнх хүмүүс өөрсдийн гэр бүлийг авч явахын тулд мал аж ахуй эрхлэх хандлагатай боллоо. Малчин өрхийн нийт тоо 1990 онд 75,000 (нийт хүн амын 17 хувь) 2000 онд 192,000 (нийт хүн амын 35 хувь) болж 2 дахин өссөн байна. Шинэ болон хуучин үеийн малчдын ахуй амьдралын хандлага, хөрөнгийн түвшин болон мал маллагааны чадвар, туршлагын хоорондын ялгаа нь тэд малынхаа бэлчээрийг солих, малаа хааш нь бэлчээх нь малчдын сонголт байдаг учраас бэлчээрийн талаархи гүнзгий мэдлэгтэй холбоотой юм.

Иймд бэлчээрийн нүүдэл болон малчдын туршлага нь бэлчээрийг талхлалтаас хамгаалахад чухал байдаг байна. Ерөнхийдөө, шинэ үеийн малчдын мал маллагааны чадвар сул, туршлага багатай байдаг бөгөөд бага нүүдэллэдэг нь суурин газар, зам харилцааг бараадаж, зах зээлд илүү ойр байдаг байна. 1990 оны сүүлчээр хөрөнгөтэй малчид бага нүүдэллэх болж, жил тойрон нүүдэллэх хамгийн сайн өвөлжөө, хаваржааг илүүтэй үзэх болсон байна. Энэ нь тэд олж авсан бэлчээрээ бусдын өмчид улирлын чанартай халдагчдаас хамгаалах зорилготой юм.

Нийт малын тоо 1990 онд 25 сая байсан бол 2000 оны сүүлчээр 30 сая толгой болтлоо эрс өссөн байна. 1993-1999 оны хооронд малын тоо толгой эрс өсөж, нийт тоо 33 сая толгойд (33 хувийн өсөлт) хүрсэн байна. Энэхүү өсөлтийн гол шалтгаан нь хөдөө аж ахуйн хамтралын дор зонхилон байсан төвлөрсөн зах зээлийн систем задарсантай холбоотой юм. Хэдэн арван жил, дотоодын болон гадаадын экспортын эрэлтийг хангаж байсан мах болон малын бусад бүтээгдэхүүний төвлөрсөн зах зээл нь үндэсний сүргийн өсөлтийг хязгаарлаж байсан байна. Учир нь Засгийн газар мал худалдан авагчийг хариуцаж, цөөн хэдэн малд



хахир өвөл/хаврын үеэр арчилгаа  
шаардагддаг байна.



Асуудал  
1999-2000 оны ахуй амьдрал болон малын  
тоо толгойн өөрчлөлт

1990 оны эхээрх энэхүү төвлөрсөн системийн уналт болон өргөн хэрэглээний барааг улсын- татаастай хувиарладаг системийн уналт нь малчин өрхүүдэд худалдаа хийхэд маш муугаар нөлөөлсөн байна. Малчид малаа өргөн хэрэглээний бараатай харьцуулахад бага үнээр зарахын оронд “амьд”-аар нь байлгахыг илүүд үзэж байв. 1990-ээд оны дунд үе буюу мөнгөний ханшгүйдэлтэй эдийн засагтай үед малчдыг тэргүүлэх сонирхол бүхий малчин өрхүүдийн тоо өсөж байсан байна.

1990 оны сүүл үед малчин өрхүүдэд худалдаа эрхлэх нөхцөл муудсан нь тэдний цаашдын амьжиргаанд сөргөөр нөлөө үзүүлсэн юм<sup>7</sup>. Иймд малчид худалдаа эрхэлж өөрсдийн амьдрал ахуйгаа сайжруулахын тулд зах зээл рүү тэмүүлэх нь их болсон байна.


Чухамдаа бүхий л шатанд хүн ам төвлөрөх явц газар авч байна. Тухайлбал, сумын хэмжээнд (алсын сумаас сумын төв рүү ойртож), аймгийн хэмжээнд (аймгийн төв рүү ойртож, үндсэндээ зам тээврийн тэнхлэгийн дагуу) болон улсын хэмжээнд (алслагдсан аймгууд, ялангуяа Монгол орны баруун аймгууд улсын төв хэсэг буюу Улаанбаатарт ойртож). Энэхүү төвлөрлийг Засгийн газар нухацтай авч хэлэлцэн, Монгол орны эдийн засгийн боломжийг илүүтэйгээр нээх үүднээс 2001 онд шинэ бүсийн хөгжлийн бодлогыг танилцуулсан байна.

---

<sup>7</sup> Монгол улсын 2000 оны байдлаархи Амьдралын түвшний стандартын үнэлгээ, Улаанбаатар: Монгол улсын Үндэсний статистикийн газар болон Дэлхийн банк, 2001.

Асуудал  
1999-2000 оны ахуй амьдрал болон малын  
тоо толгойн өөрчлөлт

1990 оноос хойш эдийн засгийн шинэ системд шилжсэнээр үндэсний сүрэгт зүйлийн бүтэц мөн өөрчлөгдсөөр байна. Дэлхийн ноолуурын үнэ өндөр (хэлбэлзэж байдаг боловч) байгаагаас нийт малын сүрэгт ямааны эзлэх хувь 1990 онд 20 хувь байсан бол 2000 онд 34 хувь болтлоо өссөнийг тэмдэглүүштэй юм. Саяхан судалгаа хийсэн хүн амын амьдралын түвшний стандартын үнэлгээнээс үзэхэд ихэнх хүмүүс Хятад руу ноолуурын худалдаа хийх боломж олдож байгаад сэтгэл хангалуун байна гэсэн дүгнэлт гарсан байна<sup>8</sup>. Ямааны нийт тоо толгойн өсөлтөд урьд ноолуурын бүтээгдэхүүний бүстэй холбоотой бус (Монгол орны хойд хэсэг) хонины тоо толгой буурч байгаатай холбоотой юм. Хонины тоо толгой 1990 онд сүргийн бүтцийн 58 хувь эзэлдэг байсан бол 2000 онд 46 хувь болтлоо буурсан байна.



Монголд бэлчээрлэж буй малын төрлүүд нь бэлчээрийн аль ч бүсээс хамгийн их ашиг шим хүртэхийн тулд хоол хүнс болон идэх хэв маягаараа өөр өөр байдаг байна. Малын төрлөөс ямаа бусдыгаа бодвол илүү сэргэлэн, цовоо бөгөөд бусад малын хүрч чаддаггүй газраас хоол олж идэж чаддаг байна. Ямаа ховордож буй бутлаг ургамал зэрэг олон төрлийн хоол тэжээл иддэг байна. Ямаа өөрсдийн хурц туурайгаараа тачир ургамалтай газрын нүцгэн хөрсийг хөгц болон бусад намхан ургамлуудын дундуур зам гарган бэлчээрлэж хөрсийг салхины элэгдэлд өртөмтгий болгодог байна. Энэ нь өнөөгийн хатуу хаврын шороон шуурга Говийн бүсэд бэлчээрлэж буй их хэмжээний ямаагаар байдлыг дордуулж байна гэсэн бодолд хүргэж байгаа юм. 1990-2000 оны хооронд үндэсний сүрэгт мал болон морины эзлэх хувь хамгийн багадаа 9-11 хувьтай байсан байна. 1999-2000 болон 2000-2001 онуудад

<sup>8</sup> Монгол улсын 2000 оны амьдралын стандартын үнэлгээ, Улаанбаатар: Монгол улсын Үндэсний статистикийн газар болон Дэлхийн банк, 2001.

дараалан болсон зуднаар эдгээр бод  
малын хорогдол бог малыг бодвол их  
байсан юм.

Асуудал  
1999-2000 оны ахуй амьдрал болон малын  
тоо толгойн өөрчлөлт

Монгол улсын Засгийн газар бэлчээрийн эрсдэлийн менежментийг дэмжихэд чиглэсэн хүчин чармайлтад ихээхэн ач холбогдол өгч байна. Хөдөөгийн ядуучуудын хөрөнгийг өсгөх урт хугацааны сорилт нь тэдний ахуй амьдралын боломжийг нэмэгдүүлж байгаа юм. Түүнчлэн, Монгол улсын Засгийн газар мал аж ахуйн салбарт тогтвортой ахуй амьдралын баталгаа муутай малчдын өнөөгийн оршин байгаа стратегийн сайжруулахыг зорьж байна. Монгол улсын ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрт микро-санхүүгийн үйлчилгээг хөдөөгийн алслагдсан бүс нутагт хүргэх тухай тусгагдсан байна.

Түүнчлэн хөдөө орон нутгийн хөгжлийг дэмжихэд чиглэгдсэн жижиг оврын дэд бүтцийг хөгжүүлэхэд хөрөнгө оруулалт хийхийг, тухайлбал, худаг ус гаргах, хөдөөгийн замыг сайжруулах, эрүүл мэнд болон боловсролыг дээшлүүлэх г.м. тэргүүлэх зорилт болгон удирдах талаар Засгийн газрын дэмжлэг чухал юм. 2000 онд хийсэн Амьжиргааны стандартын үнэлгээ нь Монгол улсын хөдөө иймэрхүү дэд бүтцийн хөрөнгө оруулалт ба үйлчилгээний хэлбэр нь бэлчээрийн газрыг ашиглах ба түүний менежментийн тогтвортой байдлын түлхүүр болох нь тогтоогдсон нүүдлийн мал аж ахуйн бүтээгдэхүүнтэй зохицно гэдгийг батлахыг хүсч байгаа нь нотлогдсон байна.

**Зуд болон хөдөөгийн эрсдэлийн менежмент**

Зуд гэдэг нь өвлийн цаг агаарын нөхцөлд малыг хамгаалах нэр томъёо юм. Зуд гэж Монголын малчдад тохиолдож буй хахир байгалийн нөхцөлдөө зохицон амьдрах гамшиг болно. Бэлчээрийг цас болон мөсний цар хучих нь Монголд тохиолддог нийтлэг зудны хэлбэр (цагаан зуд) байна. Эдгээр хур тунадас нь малын уух усны анхдагч эх үүсвэр нь болдог байна. Өвлийн бэлчээрт цас, мөс үгүй бол энэ нь зудны нэг төрөл (харын зуд) болдог байна. Бэлчээр дэх малын тэжээл нь харьцангуй богино зуны улиралд унах борооноос бүхэлдээ хамаардаг болно. Зуд нь урьд зун болсон ганг хүндрүүлдэг учир малын өвөл идэх тэжээл улам багасдаг болно. Ер нь ойролцоор 7 жил тутамд зуд тохиолддог боловч ихэнх туршлагатай малчид өнөөгийнх шиг зуд жил дараалан болж байгаад почирдоггүй байна.

1990-2000 болон 2000-2001 онуудад дараалан болсон 2 зуд мал аж ахуйн үйлдвэрлэлд Монгол улс хэр зэрэг эрсдэлтэй болохыг бодлого боловсруулагч болон олон улсын хандивлагчдад харууллаа. Өнөөгийн зудны байдал зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш урьд өмнө болж байгаагүй үзэгдэл бөгөөд үүний үр дүнд 7 сая гаруй мал буюу нийт малын 22 хувь хорогдсон байна. Ойролцоогоор 10,000 малчин өрх малгүй хоцорч, 15,000 өрх 100-аас бага малтай үлдсэн байна. Ойролцоогоор ердийн малчин өрхөд хамгийн багадаа 150 малтай айл өрх аж амьдралаа хэвийн залгуулах шаардлагыг хангадаг гэж үздэг байна. Малчин айл өрхийн 75 хувь энэхүү доод шаардлагаас бага малтай бөгөөд ган, зудын нөлөөнд хэт эмзэг байдаг байна.

Өнөөгийн тохиолдож буй зуднаас үүсч буй үр дагавар Монголын хахир байгальд аж төрөх ёсыг доройтуулж байна. Хүний аж амьдрал болон малыг аврахад хүмүүнлэгийн тусламж чухал байдаг учир Монгол улсын Засгийн газрын болон олон улсын байгууллагын тэргүүлэх чиглэл бол малчин, орон

нутгийн засаг захиргаа болон бусад өндөр албан тушаалтангууд эрсдэлд бэлэн байх байдлыг сайжруулахад чиглэсэн зохистой арга хэмжээг авах явдал юм.

*Эх үүсвэр: Зуун Ази болон Номхон далайн бүс, Хөдөөгийн хөгжил болон байгалийн нөөцийн газар, Дэлхийн банкны ажлын хэсэг.*

## Хөх үзүүлэлт Усны нөөц

Монгол улс байнгын урсгалтай 3800 гол горхи бүхий 6500 км урт усан сүлжээ үүсгэдэг. Мөн 3500 нуур цөөрөм, 186 мөсөн гол нь гадаргын усны хэмжээг 63 сая шоометрт хүргэнэ.


Хэдийгээр усны нөөц ийм их баялаг боловч түүний зөвхөн хагасыг нь л аж үйлдвэр, хөдөө аж ахуй, хүний хэрэгцээнд ашигладаг ба энэ нь нийт хэрэглээний дөнгөж 20 хувийг л хангадаг байна. Газрын гүний усны нөөц ихтэй ба энэ нь хэрэглэж буй усны 80 хувийг хангана.

Нэг хүнд ногдох жилийн усны хүрэлцээ 17300 м<sup>3</sup> боловч тус улсын бүс нутгийн хэмжээнд энэ байдал ихээхэн ялгаатай байдаг. Нэг хүнд ноогдох усны хамгийн бага хүрэлцээ Говийн бүсэд хамгийн бага буюу нэг хүнд дөнгөж 4500 м<sup>3</sup> байхад төв болон хойд хэсэгт энэ хэмжээ хамгийн өндөр буюу нэг хүнд 46000 м<sup>3</sup> байна.

Нэг хүнд ногдох усны хэрэглээ дэлхийн дундаж болон ДЭМБ-аас зөвлөмж болгосон өдөр тутмын хамгийн бага хэрэглээнээс 3-4 дахин доогуур байна. 1960-1980-аад оны хооронд усны нийт хэрэглээ гурав дахин нэмэгдсэн ч энэ байдал 1990-2000 оны хугацаанд 25 хувиар буурсан бөгөөд энэ нь шилжилтийн үеийн дараахи эдийн засгийн бууралтын үр дагавар юм.

Туул, Хараа, Хэрлэн голуудын сав газар хүн амын нягтшил ихэссэнээс эдгээр голуудын усны түвшин буурч байна. Гүний усыг ихээр ашиглах болсны уршгаар түвшин нь буурч зарим газар ялангуяа жилийн гурав, дөрөвдүгээр сард зарим булаг шанд, худаг ширгэх болсон байна.

Гүний усны 60 хүртэл хувийг арилжааны зорилгоор ямар нэгэн шаардагдах зөвшөөрөлгүйгээр татан авч байгаа ба гүний усны түвшин буурч байгаад хяналт тавих хэмжилтийн систем байхгүй байна.



Эх сурвалж: Байгаль орчны яам, Улаанбаатар, 2002 оны 3-р сар

Түүнчлэн гүний усыг ахуйн хэрэглээнд ашиглах явдал ямар ч хяналтгүй бөгөөд үүнд Засгийн газрын зөвшөөрөл шаардлагагүй байдаг.

## Хөх үзүүлэлт Усны нөөц

Тус улсын гэрт<sup>9</sup> амьдардаг хүн амын тал нь усан хангамжийн бэрхшээлтэй учирч байгаа бөгөөд тэд зөвхөн ачааны тэрэг болон хөрш зэргэлдээ байдаг худгаас түгээдэг усанд аж амьдралаа даатгадаг байна. Бодит байдалд хөдөөгийн хүн амын дөнгөж 30 хувь нь л байнгын усан хангамжтай байна. Үүнээс гадна усанд орох шүршүүр, онгоц бүхий орон сууцны хүртээмж маш их хязгаарлагдмал юм.

Төв суурин газрын усан хангамжийн хоолойнуудад засвар үйлчилгээг зохих түвшинд тогтмол хийдэггүйгээс усны нийт хэрэглээ доогуур байна. Усан хангамжийн 30 хувь нь дамжуулах замд үгүй болж, усны цорго, жорлонгоос ус алдагддагаас усны алдагдал 50 орчим хувьд хүрдэг гэсэн тооцоо гарчээ.

Усан хангамжийн сүлжээ, байгууламжуудыг өргөжүүлэх, шинэчлэх, засвар үйлчилгээ хийх ажил хөрөнгө мөнгө, чадварлаг техникийн ажилтнуудын хомсдолын уршгаар бэрхшээлтэй учирдаг. Усны нөөцийн нэгдсэн менежмент хариуцдаг байгууллагуудыг задлан жижигрүүлсэн, ус хэрэглэгчдийн янз бүрийн хэсэг бүлгүүдийн дундах ус хэрэглэх эрхийг хуваарилан олгох явдалд тэдний оролцоо байхгүй болсноос зогсонги байдалд орсон байна.

---

<sup>9</sup> Гэр гэдэг нь ердийн бөөрөнхий цагаан асар юм; гэр хороолол гэдэг нь хот, төмөр/ модон хашаанд гэр болон модон/ туйпуун байшин холилдсон хот газрын үйлчилгээнд хүрэхэд хязгаарлагдмал газар юм.

Хөх үзүүлэлт  
Усны нөөцийн бодлогын хэрэгжилт

1995 оноос Усны тухай хуулийг мөрдөж эхэлсэн юм. Энэ хуулинд Монгол улсын Засгийн газар усны нөөцийн менежментийг зохицуулж, усыг эдийн засгийн таваар гэж үзсэн байна. 1999 онд Усны тухай үндэсний хөтөлбөрт байгалийн баялгийн өнөөгийн менежмент дэх алдаа доголдлыг засч залруулах стратегийн үндсэн нөхцлүүдийг тодорхойлжээ. Усны үндэсний хороо энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байна.

Эвдэрч сүйрсэн усжуулалтын систем

Усжуулалтад ашиглаж байсан усны хэмжээ шилжилтийн жилүүдэд үлэмж хэмжээгээр багассан бөгөөд 1990-аад оны эхэн үед тус улсад 140 гаруй усжуулалтын систем байснаас одоо дөнгөж 65 хувь нь л ажиллах нөхцөл байдалд байна. Хөрөнгө мөнгө, хөрөнгө оруулалт байхгүйгээс шинээр усжуулалтын систем бариагүй төдийгүй хуучин байгаад нь ч наад захын засвар үйлчилгээ хийгээгүй ажээ. Усан хангамжийн байгууламж, машин техник, тоног төхөөрөмж ихээр хуучир хоцрогдсоны уршгаар их хэмжээний усыг үр ашиггүй хаяж байна.

Түүнчлэн малчдын ахуйн хэрэглээ болон малаа услахад ашигладаг олон тооны худаг эвдэрсэн байна. Ухаж гаргасан 48 мянган худгийн дөнгөж 40 хувь нь л одоо ашиглагдаж байна. Усжуулалтын систем, худгуудыг зохих ёсны эзэнтэй болгон, засвар үйлчилгээ хийхгүй байгаагаас усны хомсдол тус улсын хэд хэдэн бүс нутагт тун удахгүй эдийн засгийн ноцтой саад бэрхшээл үүсгэж болзошгүй гэсэн түгшүүр бий болоод байна.

1999 онд Монгол улсын Засгийн газар усжуулалтын системээс гарч буй усны хаягдлыг багасгаж, түүний ажиллагаа, засвар үйлчилгээг санхүүжүүлэх хөрөнгө мөнгөний эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор усжуулалтын системд ус хэмжигч төхөөрөмж нэвтрүүлэх төлөвлөгөө боловсруулжээ.

*Эх үүсвэр: Байгаль орчны яам, Улаанбаатар, 2002 оны 3-р сар*



## Хөх үзүүлэлт Усны чанар

Ахуйн хэрэглээний бохир ус, аж үйлдвэрийн газруудаас гарч буй хаягдал ус болон тариалангийн талбайгаас гарч буй ус болон цэвэрлээгүй хатуу, хуурай хог хаягдал Монголд газрын гадаргуугийн болон гүний усыг бохирдуулж байна. Түүнчлэн химийн бодис, бордоог зүй бусаар ашиглах, хадгалах болон ариун цэвэр- эрүүл ахуйн бүсүүдийг хамгаалах дүрэм журмыг зөрчих явдал нь дээрх асуудлыг улам хурцатгаж байна.

Өнөөгийн байдлаар, тус улсын хүн амын 60 хувийг нийтийн усан хангамжийн системээр хангадаг ба тэдний 25 хувь нь ариун цэвэр- эрүүл ахуйн газарт хандах бололцоотой байна. Төв суурин газрын ихэнх нь бохир усыг цуглуулан цэвэрлэх төвлөрсөн байгууламжтай ч дэд бүтцийн энэ салбарын дийлэнх хувийнх нь нөхцөл байдал туйлын хүнд хийгээд бүрэн хүчин чадлаараа ажиллахгүй болжээ.

Гэр хороололд бохир болон хаягдал усыг цуглуулан хураах систем байхгүй. Гэр хорооллын хашаа бүр газар ухсан жорлонтой бөгөөд түүнийг тун бүдүүлэг байдлаар барьдаг учир, эвгүй үнэр гарч, ялаа шавьж цугларч улмаар гүний усыг бохирдуулах нөхцлийг бүрдүүлдэг.

Монголын гол мөрний усыг байгалийн жамаар цэвэршүүлэх бололцоо нөхцөл нь гол мөрний улирлаас хамаарах урсац, өвөл хөлддөг зэрэг нөхцөл байдлаар хязгаарлагдаж байдаг.

Тэрэлж гол ялангуяа түүний эх авдаг хэсэг, түүнчлэн Тамир, Зэлтэрийн голууд усан дахь хүчилтөрөгчийнхөө түвшингээр 1-р зэрэглэлд багтаж байна.

Туул голын эх хэсэг 2-р зэрэглэлд орсон бол түүний адаг хэсэг нийслэл Улаанбаатар хотын эргэн тойрон дахь хүн болон аж үйлдвэрийн үйл ажиллагааны бөөгнөрлөөс шалтгаалан 4-р зэрэглэлд оржээ.

Мөн Хангал гол Монголын хамгийн том зэсийн уурхай, боловсруулах үйлдвэрийн ойролцоо урсдагийнхаа уршгаар 4-р зэрэглэлд орсон байна. Эдгээр голуудын ус нь маш өндөр хэмжээний биохимийн хүчилтөрөгчийн хэрэгцээ болон колиформын бактеритай байна.



Эх сурвалж: Байгаль орчны яам, Улаанбаатар, 2001 оны 10-р сар

## Хөх үзүүлэлт Усны чанар

Уул уурхай, мод бэлтгэлийн бүс нутгаар дайран урсдаг Орхон, тус улсын түлшний нүүрсний хамгийн том Багануурын уурхайн хажуугаар урсдаг Хэрлэн, Дархан хотын ойролцоо урсдаг Хараа зэрэг голуудын усны чанар улам доройтсоор байна. Биохимийн хүчилтөрөгчийн хэрэгцээ, хүнд металлын концентраци нэмэгдэж, усанд ууссан хүчилтөрөгчийн агуулга нь буурснаар эдгээр голууд 3-р зэрэглэлд орсон байна.

Өнгөрсөн 10 жилд газрын гүний усны хэмжээ болон чанар бохирдолд улам ихээр өртсөөр байна. Гүний усны хэрэглээ нэмэгдэж, усны дахин цэвэрших чанар удааширсан, эсвэл буурч байгаа нь гүний ус ахуйн хэрэглээний бохир ус, үйлдвэрийн газрын хаягдал болон хөдөө аж ахуйд хэрэглэж буй химийн бодисын уршгаар давсархаг болж бохирдоход хүргэж байна.

Усны чанарын хяналт хэтэрхий хязгаарлагдмал юм уу эсвэл огт байхгүй түүнчлэн хаягдал усыг цуглуулан цэвэрлэх зохих ёсны систем тус улсын олон хэсэгт дутагдалтай байгаагаас хүн амын эрүүл мэндэд үлэмж аюул учруулж байна.

## Хөх үзүүлэлт Усны чанарын бодлогын хэрэгжилт

Монгол улсын Засгийн газар үйл ажиллагааныхаа бодлогодоо “Бохирдуулагч нь төлөх ёстой” гэсэн зарчмыг мөрдөж байна. “Усны бохирдлын төлбөрийн тухай” хуулийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

Өнгөрсөн таван жилийн хугацаанд хөгжлийн талаархи хэд хэдэн хөтөлбөр тус улсад үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор усан хангамж, эрүүл ахуй- ариун цэврийн дэд бүтцийг сэргээн босгож шинэчлэн сайжруулсан юм.

Хөдөө орон нутаг, хот суурин газрын усан хангамжийн талаархи усны чанарын үндэсний стандартыг эргэн хянаж, улмаар усны чанарыг шалган тогтоох сургалт, тоног төхөөрөмжийг шинэчлээд байгаа юм. Түүнчлэн Засгийн газар Туулын голын бохирдолтод үнэлгээ хийх, бохирдлыг багасгах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулаад байна.

Дээрхээс гадна Монгол улсын Засгийн газар:

- усны үр ашигтай, тогтвортой хангамжийг бүрдүүлэх хууль эрх зүйн хүрээ,
- усыг зохих үнэ өртгөөр адил тэгш түгээн тараах нөхцлийг бүрдүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх бололцоо болон
- усны ашиглалтыг нэгдсэн байдлаар зохицуулах уян хатан байдал зэрэгт үнэлгээ хийхээр усны салбарын үйл ажиллагааг дахин хянан нягталж байна.

Хөх үзүүлэлт  
Усны чанарын бодлогын хэрэгжилт

Гадаргуугийн усны ангилал

1989 онд Монгол улсын Засгийн газар газрын гадаргуугийн усны чанарыг тодорхойлох таван зэрэглэл бүхий ангиллын системийг боловсруулсан юм. Хүчилтөрөгчийн нөхцөл, эрдсийн найрлага, органик бохирдол, биологийн хордолт, хорт бодис зэрэг хэд хэдэн үзүүлэлтээр цэвэршилтийн зэрэглэлийг тогтооно.

**1-р зэрэглэл - дараахи зүйлд ашиглах илүү цэвэр, цэнгэг гадаргуугийн усны нөөц:**

1. Ус цэвэршүүлэх үйл ажиллагаагаар дамжих шаардлагагүй хамгаалалтад зориулагдсан ус. Үүнд зөвхөн өвчин эмгэг үүсгэгчийг устгахад зориулагдсан энгийн үйл ажиллагаа шаардлагатай.
2. Үндсэн амьд организмыг байгалийн жамаар өсгөн үржүүлж болох экосистемийн хамгаалалтанд шаардлагатай ус.

**2-р зэрэглэл - дараахи зүйлд ашиглах маш цэвэр, цэнгэг гадаргуугийн усны нөөц:**

1. Хэрэглэхийн өмнө ус цэвэршүүлэх энгийн үйл ажиллагаа явуулах шаардлагатай хэрэглээний ус.
2. Усны организмыг хамгаалах, загас агнуур болон амралт сувиллын газарт ашиглах ус.

**3-р зэрэглэл - дараахи зүйлд ашиглах дунд зэргийн цэвэр, цэнгэг усны нөөц:**

1. Энгийн цэвэрлэгээ хийсний дараа хэрэглээнд ашиглах ус.
2. Хөдөө аж ахуйд ашиглаж буй ус.

**4-р зэрэглэл - дараахи зүйлд ашиглах бага зэргийн цэвэр усны нөөц:**


1. Тусгайлан цэвэрлэсний дараа хэрэглээнд ашиглах ус.
2. Аж үйлдвэрийн хэрэглээнд ашиглах ус.

**5-р зэрэглэл - Зөвхөн усан онгоцоор явахад ашиглах бохирдсон цэвэр усны нөөц.**


Өнөөгийн байдлаар Хангал, Хараа, Хэрлэн, Орхон, Тамир, Тэрэлж, Туул, Зэлтэрийн голуудыг ангилалд хамруулсан байна. Гэхдээ усны чанарыг системтэйгээр хянахгүй байгаа болно.

## Хүрэн үзүүлэлт Агаарын чанар

Монгол улсын хот суурин газруудад агаарын бохирдол өнгөрсөн 10 жилд улам ихэссээр байна. Эрчим хүч үүсгэх, халаалт болон хоол ундаа бэлтгэхэд жил бүр хэрэглэж буй 5.7 сая тонн нүүрс, 160 м<sup>3</sup> тонн мод агаарын бохирдлын түвшин нэмэгдэхийн гол шалтгаан болж байна.



Улаанбаатар хотод одоо агаарын бохирдлыг ажиглан хянах дөрвөн станц байна. Эдгээр станцуудын тогтоосноор, 1994-2000 оны хооронд SO<sub>2</sub>, NO<sub>2</sub>-ын концентраци нэмэгдсэн байна. SO<sub>2</sub> ын концентраци 4μg / м<sup>3</sup> -ээс 9μg / м<sup>3</sup>, NO<sub>2</sub>-ын концентраци 14μg / м<sup>3</sup> -ээс 25μg / м<sup>3</sup> болтлоо тус тус нэмэгджээ.



SO<sub>2</sub>-ын концентраци нь 10 дугаар сараас 3 дугаар сарын хооронд халаалтын эх үүсвэрүүд болон эрчим хүч гаргаж авах явдлаас шалтгаалан хамгийн өндөр байдаг. Эдгээр саруудад SO<sub>2</sub>-ын хамгийн оргил түвшин болох 45μg / м<sup>3</sup> орой 4-8 цагийн хооронд бүртгэгдсэн байна. Энэхүү оргил түвшингүүд жил жилийн концентрациас хоёр дахин өндөр байгаа бөгөөд өнөөгийн өсөлтийн энэхүү түвшингээр эдгээр концентрациуд нэн удахгүй тогтоогдсон стандартаас давна гэсэн түгшүүр бий болоод байна. 1990 оноос хойш автомашины тоо хоёр дахин нэмэгдсэний улмаас автомашины гол замууд болон замын уулзваруудад NO<sub>2</sub>-ын өндөр хэмжээний концентраци сүүлийн жилүүдэд ажиглагдах болсон юм. Гэхдээ эдгээр концентрациуд нь тус улсын үндэсний стандартын хэмжээнээс доогуур байгаа юм.

Хөрс хуулсан хүчтэй салхинаас үүсэх шороон шуурга, ялангуяа жилийн дөрөвдүгээр улиралд ихэд түгээмэл байдаг. Хүний үйл ажиллагаа болон байгалийн жамаар доройтон муудсан газрын эвдрэл энэ байдлыг улам ч хүндрүүлдэг байна. 1960-аад оны үетэй харьцуулбал өнөөдөр Улаанбаатарт шороон шуурга тавих явдал дөрөв дахин их болжээ.

## Хүрэн үзүүлэлт Агаарын чанар

Агаарын бохирдол нэмэгдсэний уршгаар хүүхдүүдийн<sup>10</sup> дунд амьсгалын замын өвчний хурц халдвар авах явдал эрс нэмэгдэж байгааг сүүлийн жилүүдэд явуулсан судалгаанууд харуулж байна. Тав хүртлэх насны хүүхдүүдийн дундах амьсгалын замын өвчний халдвар авах явдал Улаанбаатар хотод хөдөө орон нутгийнхаас 2-3 дахин их байна.

---

<sup>10</sup> М. Эрдэнэтуяа, Р. Эрдэнэчимэг, Монгол улсын цаг уур болон хүүхдийн эрүүл мэнд, Байгаль орчны яам, 2000 оны жилийн тайлан; Улаанбаатар, 2000.

## Хүрэн үзүүлэлт Агаарын чанарын бодлогын хэрэгжилт

1995 онд Монгол Улсын Их Хурал “Агаарын тухай хууль”-ийг баталж, 1996 онд Засгийн газар Агаарыг хамгаалах үндэсний хөтөлбөрийг тус тус батлан гаргасан байна. Энэхүү хөтөлбөрт Монгол улсын эдийн засгийн янз бүрийн салбар дахь агаарын бохирдлын мониторинг, менежментийн эн тэргүүний зорилтыг тодорхойлсон юм.

1997 оноос хойш Монгол улсын Засгийн газар Улаанбаатар хотын агаарын бохирдлын нэгдсэн менежментийн хөтөлбөрийг боловсруулахаар ажиллаж байна. Энэ хөтөлбөрийн гол онцлогууд нь илүү цэвэр түлш хэрэглэх, зах зээлд түшиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх, эрчим хүч үйлдвэрлэгчдэд зохицуулалтын урамшуулал олгох, эрчим хүчний хувьд үр ашигтай хөрөнгө оруулалт хийсэн хувийн салбарынхан болон хэрэглэгчдэд урамшуулал олгоход шилжих, түүнчлэн мониторингийг эрчимжүүлж, хүчин чадлыг бэхжүүлэх, замын хөдөлгөөний менежментийг сайжруулах зэрэг юм.

### Хотын айл өрхийн зуухыг сайжруулах төсөл


Улаанбаатар хот нь манай дэлхийн хамгийн хүйтэн нийслэл хот бөгөөд тус хотод оршин суудаг Монголчууд хоол ундаа бэлтгэх, гэр орноо дулаануулахдаа үр ашиг багатай, агаар бохирдуулагч, нүүрсээр галладаг зуух хэрэглэж байна. Үүний дүнд ойролцоогоор 70 мянган гэр хорооллын зуухнаас гарч буй утаа тортог амьсгалын замын өвчин эмгэгийн гол шалтгаан болдог байна. Бодит байдалд авч үзвэл Монгол улс нь нэг хүнд ногдох /ДНБ-ээс давсан/ хүлэмжийн хийн ялгаруулалтаар дэлхийд дээгүүрт орж буй улсуудын нэг болж байгаа юм.

Дэлхийн Байгаль орчны сангийн 750 мянган ам. долларын санхүүжилт бүхий Хотын айл өрхийн зуухыг сайжруулах төсөл гэр хорооллынхны нүүрсний хэрэглээг бууруулах арга замыг эрэлхийлж, үр ашиг сайтай, нүүрсээр галладаг гэрийн зуух үйлдвэрлэн борлуулах явдлыг урамшуулах зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан систем бий болгох, түлш эрчим хүчээр хангах хувийн жижиг нийлүүлэгчид бий болгох үйл явцыг өрнүүлж байна. Тус төслийнхөн эндээс олж авсан сургамж, туршлагаа Монголын бусад бүс нутаг, ялангуяа аймгуудын төвд хэрэгжүүлэхийг зорьж байгаа болно.


*Эх үүсвэр: Байгаль орчин, Нийгмийн хөгжлийн алба, Зүүн Ази, Номхон Далайн бүс нутаг, Дэлхийн Банк, 2002 оны 3 дугаар сар*

## Хүрэн үзүүлэлт Хатуу болон аюултай хог хаягдал

Хөдөө орон нутгаас Улаанбаатар хот руу хүн ам ихээр шилжин суурьшиж, дагуул хотууд эрчимтэй хөгжиж байгаа нь хуурай хатуу хог хаягдлын асуудал хүндэрч байна. Нийслэл Улаанбаатар хот жил бүр дунджаар 600 мянган м<sup>3</sup> хуурай хатуу хог хаягдал гаргадаг. Үүний дөнгөж 30 хувийг цуглуулдаг ба айл өрхийн 40 хувь нь хог хаягдал цуглуулан хаях үйлчилгээнд хамрагдах бололцоотой байна.



Олон давхар орон сууцны байшингуудад хуурай хатуу хог хаягдлыг нэгдүгээр давхрын хогийн савд бөөгнөрүүлж, түүнийг нь хот тохижилтын компаниуд цуглуулан авдаг. Харин цөөхөн давхар байшингуудын гадаа нийтийн хогийн савнууд бий. Хэдийгээр эдгээр хог хаягдлыг долоо хоногт хоёр удаа цуглуулан авч явах ёстой ч өнөөгийн байдалд түүнийг долоо хоногт нэг удаа цэвэрлэдэг учир тэндээс эвгүй үнэр гарч улмаар цэвэрч байдлын асуудал үүсдэг байна.



Гэр хороололд хуурай хатуу хог хаягдлыг тусгайлсан задгай газарт хаядаг ба тийш хүрэх зам харгуй саадгүй бол хогийг сард нэг удаа авдаг байна. Газрын эвдрэл, элэгдлийн улмаас ихэнх зам харгуй тааруухан нөхцөлтэй байгаа болон хог хаясан газар нь хогийн машин очиж хог ачихад ихээхэн хүндрэлтэй хазгай налуу газар байрлаж байна. Үүний уршгаар хувь хүмүүс хогоо ойролцоо гуу жалганд асгадаг байна. Зуухнаас гарсан нүүрсний үнс нь энэхүү хог хаягдлын тал хувиас илүүг эзэлж байгаа ба энэ нь агаарын бохирдлыг улам ихэсгэдэг байна.

Тус улсын нутаг дэвсгэрт хог цуглуулах 447 цэг байдгийн 220 нь Улаанбаатар хотод бий. Хог цуглуулах болон устгах ажлыг сайн зохион байгуулахгүй байна. Хог хаягдлыг устган ариутгах газар байхгүй учир хуурай хатуу хог хаягдлыг хог устгах задгай гурван газрын аль нэг рүү ачихын өмнө хот болон хүн амь суурьшсан газрын захаар овоорон бөөгнөрдөг болно. 1990 оныг хүртэл хуурай хатуу хог хаягдлыг шатааж устгах нь гол арга байжээ.

## Хүрэн үзүүлэлт Хатуу болон аюултай хог хаягдал

Агаарын чанар муудаж эхэлсэн нь хүмүүсийг энэ аргыг хэрэглэхийг хязгаарлахад хүргэсэн ч хогны хэмжээг багасгахын тулд шатааж устгах аргыг өнөөг хүртэл хэрэглэж байгаа болон хог дээр амьдарч байгаа хүмүүс өвлийн хүйтэнд дулаацахын тулд хогийг шатаасаар байна.

Түүнчлэн эмнэлгийн хог хаягдлыг устгах тусгай байгууламж байхгүй юм. Иймд энэ төрлийн хог хаягдлыг хог устгах газрын тусгай хэсэгт ил задгай шатаадаг байна. Энэ арга нь хүний эрүүл мэндэд аюул учруулж, газрын гүний ус болон хөрсийг бохирдуулахад хүргэж байна.

Түүнчлэн химийн хортой хог хаягдлын менежмент ч сул байна. Химийн хортой бодисын хаягдлын 20 хувийг стандартын бус агуулахад хадгалдаг бол бусад 20 хувийг нь ил задгай газар хадгалж байна. Химийн хортой хаягдлыг тээвэрлэх, хадгалах талаар эрүүл мэнд, байгаль орчны эрсдлийн ангиллын систем одоогоор байхгүй учир химийн хортой хаягдлын зүй бус менежмент, устгалаас үүдэлтэй ус болон хөрсний бохирдол бий болж болзошгүй байдал улам өсөн нэмэгдэж байна.



Хүрэн үзүүлэлт  
Хатуу болон аюултай хог хаягдлын  
бодлогын хэрэгжилт

Монгол улсын Засгийн газраас саяхан баталсан “Хуурай хатуу хог хаягдлыг бууруулах хөтөлбөр”-ийг одоогоор нилээд хэдэн аймаг, суурин газруудад хэрэгжүүлж эхлээд байгаа юм.

Хог хаягдал асгах ил задгай газрыг бүртгэх лицензийн систем бий болгож, хог хаягдал хууль бусаар хаясан ил задгай хэд хэдэн газрыг улсын хэмжээнд хаагаад байна. Түүнчлэн хатуу хуурай хог хаягдлын 70-80 хувийг дахин боловсруулах боломжтой учир Монгол улсын Засгийн газар хог хаягдал дахин боловсруулах эдийн засгийн боломж бололцоог судалж байна.

“Хортой хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх”-д хяналт тавих тухай Базелийн конвенцийг баталсантай холбогдуулан Монгол улсын Засгийн газар хортой болон химийн бодисыг бүртгэн ангилахад чиглэсэн мэдээллийн санг байгуулж, хортой болон аюултай хог хаягдлын тухай хуулийн төслийг боловсруулж байна.

## Байгаль орчны байгууллагууд

Байгаль орчны яам (БОЯ) анх 1992 онд байгуулагдсан бөгөөд тус яам нь байгаль орчны талаархи бодлого, хууль тогтоомжийг боловсруулан хэрэгжүүлэх, байгалийн нөөцийн ашиглалтыг зохицуулах, байгаль орчныг нөхөн сэргээх хөтөлбөрүүдийг боловсруулах асуудлыг хариуцдаг. Тус яам нь газрын менежмент, усны нөөц, түүний чанар, ой болон ойжуулалт, биологийн төрөл зүйл (амьтан, ургамлын аймаг), тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент, агаар болон байгаль орчны болон байгалийн гамшгийн менежмент зэрэг байгаль орчны асуудлуудыг хариуцдаг болно.

1998 онд төвлөрсөн бүтцийг задлах зорилгоор БОЯ-ыг шинэчлэн зохион байгуулсан бөгөөд орон нутгийн Засаг дарга нар аймаг, нийслэл, сум, дүүрэг, хороо, багийн түвшинд байгаль орчны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, байгалийн баялгийг ашиглах заавар журмыг боловсруулах, байгаль орчны стандартуудын мониторинг, байгаль орчны хууль дүрмийг мөрдүүлэх, орон нутгийн байгаль орчны нөхцөл байдлын талаарх мэдээ баримтаар төрийн захиргааны төв байгууллагуудыг хангаж байх үүрэгтэй.

### Байгаль орчны салбарын байгууллагуудын бүтэц



Эх үүсвэр: Байгаль орчны яам, Улаанбаатар, 2002 оны 3 дугаар сар

Сум = хөдөөгийн бүсийн нэг дүүрэг

Баг = хөдөөгийн бүсийн дэд дүүрэг

Дүүрэг = хотын тойрог

Хороо = хотын дэд дүүрэг

Түүнчлэн Монгол улсын талаархи товч мэдээллийг үзнэ үү.

БОЯ нь байгаль орчин болон байгалийн нөөцийн менежментийн бодлогыг томъёолон боловсруулах, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх гол хөдөлгөгч хүчин хэвээр байгаа боловч Засгийн газрын зарим

## Байгаль орчны байгууллагууд

байгууллагуудын үүрэг хариуцлага БОЯ-ыхтай давхцаж байгаа юм. Тухайлбал, Эрүүл мэндийн яам (ЭМЯ) агаар бохирдуулагч бодисын ялгаруулалтын стандартыг тогтоох, агаарын бохирдлыг хэмжих, түүний хүний эрүүл мэндэд учруулах хор нөлөөг тогтоох асуудлыг мөн хариуцдаг бол Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам (БСШУЯ) нь экологийн боловсрол, олон нийтийн мэдээлэл сурталчилгааны хөтөлбөрүүдийг томъёолон хэрэгжүүлэх асуудлыг хариуцдаг байна. Үйлдвэр худалдааны яам (ҮХЯ) ойг арилжааны зорилгоор ашиглах асуудлыг мөн хариуцдаг болно.

Бүхэлд нь авч үзвэл Засгийн газрын яамд, агентлагуудын хоорондын үйл ажиллагаанд системтэй, албан ёсны зохицуулалт байхгүй төдийгүй салбарын асуудлуудаар харилцан лавлах материал байдаггүй учир тэдний үйл ажиллагааны хоорондын зохицуулалт ихээхэн хязгаарлагдмал байдалтай байдаг. БОЯ-нд одоогоор улсын болон орон нутгийн түвшинд 3900 ажилтан ажиллаж байгаа ч хүний нөөцийн болон санхүүгийн хүчин чадал нь тус яамны одоо явуулж байгаа бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт тавих, хууль журмыг мөрдүүлэх зэрэгт хангалтгүй байна. Түүнчлэн мэргэшсэн боловсон хүчнүүдээ хувийн салбарт алдаж байгаа нь энэ асуудлыг улам хурцатгаж байна. Түүнээс гадна аймаг, сум, багийн түвшин дэх байгаль орчны байгууллага, агентлагуудын захиргааны бүтэц, зохион байгуулалт сул дорой хийгээд тэдний салбарын нийт бодлого, чиглэлийн талаар улсын эрх барих байгууллагууд хоорондын үйл ажиллагааны зохицуулалт .. үндсэн дээр явагддаг байна.

Мянганы Хөгжлийн Зорилтыг батлах замаар БОЯ иргэний нийгэм, байгаль орчны менежмент дэх ТББ-ын оролцоог өргөжүүлэх, байгаль орчны менежмент дэх орон нутгийн засаг захиргааныхны үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэхийн тулд тэдний хүчин чадлыг бэхжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаагаа шинэчлэж эхлээд байна.

## Байгаль орчны байгууллагууд

### Байгаль орчны мэдээлэл сурталчилгаа

Монгол улсын иргэд улс орных нь байгаль орчны нөхцөл байдал доройтон муудсаар байгааг улам бүр ухаарч ойлгож байна. Гэвч байгаль орчны чанар муудан доройтож байгаагийн үндсэн учир шалтгааны талаархи тэдний мэдлэг, ойлголт хангалтгүй байгаа бөгөөд ингэснээр олон нийт байгалийн нөөцийг ашиглах, хамгаалахад илүү идэвхтэй оролцоход ихээхэн бэрхшээлтэй болж байгаа юм.

1995 онд Монгол улсын Засгийн газар, Соросын сангийн хамтаар байгаль орчны өнөөгийн нөхцөл байдлын эдийн засаг, нийгэмд үзүүлж буй үр нөлөөний талаар их сургуулийн багш, оюутан, дунд сургуулийн багш нарт зориулан зайны сургалт явуулж эхэлсэн юм. 1997 онд Монгол улсын Засгийн газар “Байгаль орчны мэдээлэл сурталчилгааны үндэсний хөтөлбөр” баталж, хөтөлбөрийн үйл ажиллагаа, ялангуяа үндэсний төв телевизээр байгаль орчны цуврал баримтат кино нэвтрүүлэх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулах Үндэсний Зөвлөлийг байгуулсан юм. 1999 онд БОЯ, БСШУЯ байгаль орчин, экологийн хичээлийн хөтөлбөр боловсруулах Экологийн сургалтын төвийг байгуулав. Тус хоёр яам хамтран байгаль орчин, экологийн боловсролын гарын авлага болох экологийн үндсэн сурах бичгийг хэвлэн гаргасан байна.

БОЯ байгаль орчны талаар томоохон шийдвэр гаргахад олон нийтийн санаа бодлыг тусгах, Засгийн газрын агентлагууд, ТББ-ын хоорондох олон нийтийн оролцоог орон нутаг болон улсын хэмжээнд зохицуулж байх Иргэний Нийгмийн Хороо байгуулсан байна. Байгаль орчинтой холбоотой мэдээллийг түгээн тараах, байгаль орчны хууль журмыг олон нийтэд сурталчлах мэдээллийн хэсгийг саяхан байгуулсан болно. Өнгөрсөн 10 жилд байгаль орчны 40 гаруй ТББ бий болсон бөгөөд тэдний 30 орчим нь 1999 онд Монголын байгаль орчны ТББ-уудын холбоог байгуулсан юм.

Байгаль орчны мэдээллийн талаархи нийтлэлүүдийг “Өдрийн мэдээ” сонин, “Экологийн хамгаалал” нэвтрүүлгийг үндэсний радиогоор тогтмол дамжуулах болсон.

*Эх үүсвэр: Байгаль орчны яам, Улаанбаатар, 2002 оны 3 дугаар сар*

## Байгаль орчны талаарх хууль тогтоомжууд

1992 онд баталсан Монгол улсын Үндсэн хуульд (16 дугаар зүйл) Монгол улсын иргэдийн цэвэр, аюулгүй, эрүүл орчинд аж төрөх үндсэн эрхийг тунхагласан бөгөөд “Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын бодлого”, “Үндэсний хөгжлийн стратеги”, “Монгол улсын төрөөс экологийн талаар баримтлах бодлого”-ууд Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн заалтыг улам бататгаж, байгаль орчин, байгалийн нөөцийг хамгаалах үндсэн зарчмуудыг тодорхойлсон байна.

1995 онд байгаль орчны талаархи хуучин хууль тогтоомжуудыг шинэчлэн сайжруулах зорилгоор 14 багц хуулийг баталжээ. Эдгээр хуулинд тус улсын байгаль орчны асуудал хариуцдаг байгууллагуудын шинэ бүтэц зохион байгуулалт, байгаль орчны талаархи олон улсын сүүлийн үеийн хууль дүрмүүдээс тусгасан байна. 1995 онд баталсан хуулиуд байгалийн нөөцийг хамгаалах, байгаль орчны хууль журмуудыг чангатгахаар заасан байна. Эдгээр хууль зах зээлийн эрэлт хэрэгцээг хангах анхан шатны эхлэл болгон мониторингийн хяналт шалгалт явуулах, бүртгэл хөтлөх, мэдээлэл хуваалцах, байгалийн баялаг ашигласны төлбөр хураамж авах зэрэг асуудлыг тусгасан байна.

### Байгаль орчны гол хуулиуд

- Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль, 1994
- Газрын хэвлийн баялгийн тухай хууль, 1994
- Агаарын тухай хууль, 1995
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995
- Ойн тухай хууль, 1995
- Химийн хорт бодисоос хамгаалах тухай хууль, 1995
- Агнуурын тухай хууль, 1995
- Газрын тухай хууль, 1995
- Ашигт малтмалын тухай хууль, 1995
- Байгалийн ургамлын тухай хууль, 1995
- Байгалийн баялаг, ой, ус ашигласны төлбөрийн тухай хууль, 1995
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, 1995
- Усны тухай хууль, 1995
- Ой, хээрийн түймрээс хамгаалах тухай хууль, 1996
- Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль, 1997
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 1998
- Газрын кадастрын тухай хууль, 1999

*Эх үүсвэр: Байгаль орчны яам, Улаанбаатар, 2001*

**Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ  
хийх журам**

1998 онд Монгол Улсын Их Хурал байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх, хөгжлийн талаарх төслүүдийг хэрэгжүүлэх асуудлаар шийдвэр гаргах асуудлыг зохицуулах зорилгоор анх удаа Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг баталжээ. Хөгжлийн талаар санал болгож буй төсөл бүрийг хэрэгжүүлэхийн өмнө анхан шатны шалгалт хийх, үнэлгээ хийх зохистой хэлбэр, түүний цар хүрээг тодорхойлж байхыг тус хуулинд заасан байна. Ерөнхий үнэлгээг улс (БОЯ-ны), аймаг (нэг үнэлгээний мэргэжилтэн, нэг байцаагч), сумын (нэг үнэлгээний мэргэжилтэн) байгаль орчны үнэлгээний газрын мэргэжилтнүүд хийж гүйцэтгэнэ. Байгаль орчны үнэлгээний тайланг БОЯ-аас үнэлгээ хийх зөвшөөрөл авсан хувийн пүүс компаниуд бэлтгэнэ. Анхан шатны шалгалт хийсний эцэст БОЯ эсвэл орон нутгийн эрх баригчид тухайн төсөл, ялангуяа (1) төслийн үр нөлөө байгаль орчны өнөөгийн стандарт болон шаардлагыг хангаж байгаа эсэх болон уг төсөлд ахин үнэлгээ хийлгүйгээр зөвшөөрөл өгч болох эсэх, (2) төслийн сөрөг нөлөө нь тусгай нөхцөл болзол шаардах эсэх, (3) тухайн төслийн сөрөг нөлөө байгаль орчны нарийвчилсан үнэлгээ шаардах эсэхийг харгалзан хэсэгчилсэн эсвэл бүрэн хэмжээний үнэлгээ хийх шаардлагатай эсэхийг шийдвэрлэнэ.

1 болон 2 дугаар төрлийн үнэлгээг орон нутгийн түвшинд (аймаг, сум) хянан шалгана. 3 дугаар төрлийн үнэлгээг байгаль орчны үнэлгээний улсын мэргэжилтэн шалгах ба боломжтой бол орон нутгийн түвшинд нь шалгана. Уул уурхайн төслүүдийн хувьд БОНУ-ний тухай хуулинд зааснаар байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тухайн төслийн саналд хавсаргах ёстой. Түүнчлэн, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тооцоолсон өртгийн тал хувийг орон нутгийн засаг захиргаанд бонд хэлбэрээр урьдчилан төлөхийг тус хуулинд заасан байна. Дээрх төлөвлөгөөний үлдсэн 50 хувийг төслийг хэрэгжүүлэх хугацаанд төлнө. 1999 онд Засгийн газар байгаль орчны үнэлгээг хийж, түүнд хяналт тавих асуудлыг сайжруулахын ач холбогдлыг ойлгон ухаарсны дүнд улс даяар үнэлгээний мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан юм. Түүнээс хойш сургалт болон түүнийг шинэчлэн сайжруулах ажил хийгдээгүй байна. Гэвч Монгол улсын Засгийн газар 1998 онд баталсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн үр ашгийг сайжруулахын тулд түүнийг эргэн хянаж байна.

*Эх сурвалж: Байгаль орчны яам, Улаанбаатар, 1998*

“21-р зууны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Байгаль орчны мэдээлэл сурталчилгааны хөтөлбөр” зэрэг цөлжилттэй тэмцэх, биологийн төрөл, зүйлийг хамгаалах, ой хамгаалах, хог хаягдлыг багасгахад чиглэсэн үндэсний хэмжээний хэд хэдэн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна.

1997-2000 оны хооронд “Төрөөс экологийн талаар баримтлах бодлого”, “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг байгаль хамгаалалд зарцуулах тухай хууль” зэрэг хэд хэдэн шинээр батлагдсан хуулиуд нь 1995 онд батлагдсан байгаль орчны хуулиудын сул цоорхойг нөхсөн юм. Эдгээр хуулиуд нь байгаль

орчны хууль тогтоомжийн хэрэгжилтийг чангатгах, ил тод бөгөөд хатуу чанга засаг захиргаа, иргэний үүрэг хариуцлагыг нэвтрүүлэх, байгалийн нөөцийг тогтвортой ашиглах хууль эрх зүй, эдийн засаг, байгууллагын орчин нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгджээ.

Газрын хувьчлал, хог хаягдлын менежмент, хорт бодисын хаягдлын стандарт, биологийн төрөл зүйлийг хамгаалах, байгалийн гамшиг, захиргааны хариуцлагын талаар хууль журам гаргахтай холбогдсон асуудлууд өнөөг хүртэл шийдэгдээгүй байна.

Дээрх хуулиудын хэрэгжилт ч мөн сул байна. Санхүүгийн нөөц хязгаарлагдмал, хяналт шалгалт явуулах заавар журам байхгүй зэрэг байдал орон нутгийн засаг захиргааг хуулиар олгогдсон үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэхэд ихээхэн саад тогтор болдог. Түүнчлэн, байгалийн нөөцийн ашиглалтын талаархи хяналт- шинжилгээ хангалтгүй, байгаль орчны хууль журмын талаархи олон нийтийн мэдээлэл, ойлголт хязгаарлагдмал байгаа нь одоо мөрдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг сааруулж байна.

**Хүний аюулгүй байдлыг хангах Сайн Засаглал хөтөлбөр болон  
Байгаль орчны үйл ажиллагааны үндэсний  
хөтөлбөр**

2001 онд баталсан “Хүний аюулгүй байдлыг хангах Сайн Засаглал хөтөлбөр” нь Монгол улсын Засгийн газрын албан ёсны хөтөлбөр юм. Бодлогын талаархи энэ баримт бичиг нь Монгол улсад тулгарч буй эдийн засаг, санхүү, улс төр, нийгэм, байгаль орчны талаархи саад бэрхшээлийг гэтлэн давах зорилготой.

Энэ хөтөлбөрт 11 тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон бөгөөд үүнээс дараахи гурван асуудал нь байгаль орчны асуудалтай холбоотой юм. Үүнд: (1) Тогтвортой хөгжил, экологийн тэнцвэрт байдлыг хангах байгаль орчны бодлогыг бүс нутгийн нийгэм- эдийн засгийн хөгжлийн чиглэлтэй уялдуулан хэрэгжүүлэх, (2) Газрын шинэчлэлийг эрчимжүүлэх, (3) Томоохон хот, суурин газруудын агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, хог хаягдлыг дахин боловсруулах замаар иргэдийн амьдрах орчныг сайжруулах зэрэг болно.

1995 онд баталсан Байгаль орчны үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийн зорилго нь Хүний аюулгүй байдлыг хангах Сайн Засаглал хөтөлбөрт тодорхойлсон тэргүүлэх чиглэлүүдтэй нийцэж байна. Энэ хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг Хүний аюулгүй байдлыг хангах Сайн Засаглал хөтөлбөрийн ирэх хэдэн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан байна. Үүнд байгаль орчин, байгалийн нөөцийг тогтвортой ашиглах, хүчин чадлыг бэхжүүлэх, олон нийтийн мэдээлэл, оролцоог сайжруулах, бохирдлыг багасгах болон цөлжилттэй тэмцэх зэрэг орж байгаа ажээ.

*Эх сурвалж: Байгаль орчны яам, Улаанбаатар*

## Байгаль орчны зардал

БОЯ өөрийн газар, агентлагаар дамжуулан байгаль орчны чанарын менежмент, байгалийн нөөцийн менежмент, судалгаа шинжилгээ болон усан хангамжийг сайжруулах үйл ажиллагаанд олгосон төсвийг зохицуулдаг<sup>11</sup>.

Comment [U1]:

Ойн түймрээс учирсан зардлыг нөхөх асуудлыг Батлан хамгаалах яам (БХЯ) хариуцдаг бөгөөд энэ нь улс оронд гарсан түймрийн тохиолдол бүр дээр үндэслэнэ.

Байгаль орчны зардлын талаар БОЯ-ны бус агентлагуудын гаргасан тоо баримт хязгаарлагдмал байдаг бөгөөд энэ нь байгаль орчны менежментийн гол чиг шугам нь мөн л хязгаарлагдмал байдгийг илтгэн харуулж байна. Байгаль орчны яамны харьяа агентлагуудын зардлын дийлэнх хувь нь “цэвэр” байгаль орчны менежментийн үйл ажиллагаанд<sup>12</sup> чиглэгддэг. БОЯ-ны бус байгаль орчны агентлагууд дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд туйлын хязгаарлагдмал хүрээнд оролцдог.


1996-2000 оны санхүүгийн жилд<sup>13</sup> байгаль орчны зардалд зориулан олгосон төсөв 1996 онд 1,315 сая төгрөг байснаа 2000<sup>14</sup> онд 5,309 сая төгрөг болтлоо нэмэгдэж жил бүр дунджаар 33 хувиар өсчээ. Энэхүү өссөн хандлага төсвийн хуваарилалтыг 48 хувиар хассан 1999 онд л буурсан ажээ.

Эдийн засгийн уналтын жилүүдэд Засгийн газрын нийт зардал буурсан үед байгаль орчны зардал буурсан ба энэхүү бууралт нь илүү хурдацтай хийгээд урт удаан хугацаагаар үргэлжилж байв.

1996 - 2000 оны байгаль орчны зардал

	1996	1997	1998	1999	2000
Байгаль орчны нийт зардал (сая төгрөг)	1.31	1.39	3.46	2.34	5.30
ДНБ-нд эзлэх байгаль орчны зардал	0.2	0.17	0.42	0.27	0.5
Нэг хүнд ногдох байгаль орчны зардал (ам. доллар)	0.53	0.56	1.13	0.63	1.48

Эх сурвалж: Сангийн яам, Улаанбаатар, 2001 оны 10 дугаар сар



Эх сурвалж: Байгаль орчны яам, Улаанбаатар, 2001 оны 10 дугаар сар

1996-2000 оны санхүүгийн жилүүдийн хугацаанд нийт төсвийн 58 хувийг БОЯ-нд байгаль орчны чанарын менежментэд, 39 хувийг байгалийн нөөцийн менежментэд, 2 хувийг судалгаа, хөгжлийн асуудалд зориулан олгожээ. Энэ

<sup>11</sup> Газар, хэлтсүүдэд Мэдээлэл, тооцооллын төв; Мэдээлэл, хяналт- шинжилгээ, үнэлгээний газар; Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар; Газрын хэрэг эрхлэх газар; Хамтын ажиллагааны хэлтэс хамрагдана.

<sup>12</sup> “Цэвэр” байгаль орчны менежментийн үйл ажиллагаанд: байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчны хяналт- шинжилгээ болон байгаль орчны стандарт болон хууль тогтоомжийн мөрдөлт.

<sup>13</sup> Санхүүгийн буюу төсвийн жил нь 1 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 31 дуусталх хугацаа юм.

<sup>14</sup> 1996 онд 1 ам. доллар 997.24 төгрөг байв; 2000 онд 1429.29 төгрөгтэй тэнцүү байлаа. Олон улсын Санхүүгийн статистик, 2002 он; ОУВС.



гурван үзүүлэлтүүдийн зардлын хуваарилалт жилээс жилд үлэмж ялгаатай байв. Энэ нь байгаль орчны чанарын менежмент болон судалгаа, хөгжлийн асуудалд анхаарал бага тавьж, харин байгалийн нөөцийн менежмент, “ойн түймрээс учирсан хохирлыг нөхөх зардлын”-ын асуудалд илүүтэй анхаарах болсныг харуулж байгаа юм.


Дээрх хоёр үзүүлэлт дэх асуудлууд Монгол улсын хамгийн их бэрхшээлтэй байгаль орчны асуудал болж байгаа учир Монгол улсын Засгийн газраас “Хүрэн” болон “Ногоон” үзүүлэлтүүд дэх зардлын хоорондын тэнцвэрт байдлыг хадгалахын төлөө тавьсан хүчин чармайлтын үр дүн нь дээрх хандлага юм.

Comment [U2]:

1996-1998 оны санхүүгийн жилд Монгол улсын Засгийн газраас үйлдвэрийн бохирдлын хяналтад зориулан олгосон төсөв нь нийт зардлын дөнгөж 30 хувийг эзэлж байсан ба 1998 оноос хойш Засгийн газраас үйлдвэрийн бохирдлын хяналтад ямар ч зардал төсөв олгоогүй байна. Харин хувийн хэвшлийнхэн болон хоёр талын хандивлагчид үүнд шаардлагатай зардлын зарим хэсгийн олгожээ.

Хог хаягдлын асуудлыг байгаль орчны гол асуудлуудын нэг гэж тодорхойлсон хэдий ч хог хаягдлын менежментэд 1996-2000 оны хугацаанд улсын хэмжээнд ямар ч төсөв олгоогүй байна. 2000 онд хуурай хатуу хог хаягдлын асуудал улам ноцтой болж ирсэн учир олон улсын хандивлагчдын бүлэглэл 1,194 сая төгрөгийг Монгол улсын Засгийн газарт тусламжийн хэлбэрээр олгожээ.

Байгалийн нөөц ашигласнаас олох орлого нь Монгол улсын Засгийн газрын төсөвт онцгой ач холбогдолтой юм. 1996-2000 оны хооронд байгалийн нөөц ашигласнаас олсон орлого ДНБ-д дунджаар 2 хувь болж байсан бол байгаль орчны дундаж зардал ДНБ-нд 0.3 хувийг эзэлж, байгалийн нөөцөд түшиглэсэн нийт ашиг орлогын дөнгөж 17 хувь /дунджаар/ болж байжээ.



Эх сурвалж: Сангийн яам, Улаанбаатар, 2001 оны 10 дугаар сар

Хөгжлийн асуудалд зориулсан төсвийн байгаль орчны зардлын талаархи нарийвчилсан мэдээлэл тун хомс учир нь Сангийн яамны тоо баримт зөвхөн хөгжлийн хөтөлбөрүүдийг тусгаад тэрүү хөтөлбөрүүдийн бие даасан төслүүдийг хамруулдаггүй байна. Олдож байгаа цорын ганц тоо баримт нь ойн салбарын хь хөрөнгө оруулалтын тухай мэдээлэл бөгөөд 1996 онд 109 сая төгрөг байсан тус салбарын хөрөнгө оруулалт 2000 онд 540 сая төгрөг болтлоо нэмэгдэж 20 хувиар өсчээ.

## Хандивлагчдын тусламж

Монгол улсад байгаль орчны үүсгэл санаачлагыг дэмжихэд чиглэсэн албан ёсны хөгжлийн туслалцааг гол хүлээн авагч нь БОЯ юм.

Гадаадын гол хандивлагчид нь Азийн хөгжлийн банк /АХБ/, Австралийн олон улсын хөгжлийн агентлаг /АОУХА/, Канадын олон улсын хөгжлийн агентлаг /КОУХА/, Данийн олон улсын хөгжлийн агентлаг /ДОУХА/, Даян дэлхийн байгаль орчны сан /ДДБОС/, Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг /ГТХАН/, Шинэ Зеландын Засгийн газар, Японы олон улсын хамтын ажиллагааны банк /ЯОУХАБ/, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр /НҮБХХ/, АНУ-ын олон улсын хөгжлийн агентлаг /АНУОУХА/, Дэлхийн банк /ДБ/ юм. 1993-1999 оны хооронд байгаль орчныг хамгаалах үүсгэл санаачлагыг дэмжихэд чиглэсэн хоёр талын болон олон талт хандивлагчдын туслалцаа 20 сая ам.доллар хүрсэн байна.

Байгаль орчны хамгийн идэвхтэй хандивлагч нь НҮБХХ байгууллага юм. Тус байгууллага “21-р зууны үйл ажиллагааны хөтөлбөр” төслийн бэлтгэл ажилд туслалцаа дэмжлэг үзүүлж, ойжуулалт, байгалийн гамшгийн менежмент, эрчим хүчний үр ашгийг сайжруулах, озоны давхаргыг гэмтээгч бодисыг хязгаарлах зэрэг олон санаачлагыг гаргасан байна.

НҮБХХ Дани болон Голландын Засгийн газруудтай түншлэлийн холбоо тогтоон Туул голын усны чанарыг сайжруулах менежментийн төлөвлөгөө боловсруулсан бол ДДБОС цаг уурын өөрчлөлтийн үр дагаварт үнэлгээ хийх, Монголын байгаль орчны хамгийн том төсөл болох Дорнод Монголын биологийн төрөл зүйлийг хамгаалах /9.8 сая ам.доллар/ төслүүдэд дэмжлэг үзүүлж байна.

КОУХА/ОУХСТ (Олон улсын хөгжлийн судалгааны төв) хамтран байгалийн нөөцийн эдийн засгийн үнэлгээ, байгаль орчны өртгийг тооцоолоход туслалцаа үзүүлснээс гадна Пржевальскийн адуу буюу тахийг Улаанбаатар хотоос баруун тийш орших байгалийн цогцолбор газарт сэргээн нутагшуулах ажилд дэмжлэг үзүүлсэн байна. Энэ төсөлд Голландын Засгийн газар энэ төслийн талаархи олон нийтийн мэдээлэл сурталчилгааг сайжруулах төслийг санхүүжүүлсэн байна.

БОЯ-нд байгаль орчны менежментийн ур чадварыг бэхжүүлэх зорилготой анхны техникийн туслалцааг 1995 онд АХБ санхүүжүүлсэн бөгөөд одоо тус банк тусламж дэмжлэгээ ядуу дорой амьдралтай гэр хорооллынхонд хот маягийн байгаль орчны үйлчилгээг сайжруулахад чиглүүлж байна.

Хэнтий болон Говийн бүсийн хамгаалалттай газар нутгийн эргэн тойрон дахь орчны бүсийн менежмент болон Хэнтийн нурууны ойн гал түймрийн нэгдсэн менежмент төслүүдийг ГТХАН санхүүжүүлж байна.

ЯОУХАА хаягдал ус болон хатуу хог хаягдлын менежментийн асуудлыг шийдвэрлэх төслүүдийг санхүүжүүлэхийн зэрэгцээ Улаанбаатар хотын нүүрсээр ажилладаг дулааны цахилгаан станцуудад бохирдлыг багасгах тоног төхөөрөмж нийлүүлж байгаа болно.

ДБ 1995 болон 2002 онд Байгаль орчны үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийг боловсруулахад дэмжлэг үзүүлж, улмаар салбарын байгаль орчны үнэлгээг боловсруулахад туслалцаа үзүүлж байна. Санхүү, тээвэр болон

хөдөөгийн балбаруудад хэрэгжүүлж буй төслүүдээрээ дамжуулан тус банк байгаль орчны үнэлгээ хийх үйл явц бий болгоход тусалсан юм.

ДБ Монгол улсын Засгийн газарт цаг агаарын байдалд үндэслэсэн, арилжааны хувьд хөл дээрээ тогтох мал аж ахуйн даатгал бий болгоход туслалцаа үзүүлж байна. ДДБОС-ийн дэмжлэгтэйгээр ДБ эрчим хүчний хувьд үр ашигтай хот суурин газрын айл өрхийн зуух нэвтрүүлэх, биологийн төрөл зүйлийн чадавхийг бэхжүүлэх, мөнх цэвдэг хайлснаас биологийн төрөл зүйл устан үгүй болж байгаа эсэхийг судлан тогтоох зорилгоор Хөвсгөл нуурын Байгалийн Цогцолбор газарт судалгаа явуулах зэрэг төслүүдийг удирдан зохицуулж байна.

## Байгаль орчны нэр томъёоны хураангуй

**Агаарын чанарын стандарт:** Тодорхой газар нутагт тогтоосон цаг хугацаанд дүрэм журамд заасан хэмжээнээс хэтрэхгүй байх бохирдуулагч бодисын хэмжээ.

**Хуурайшилт:** Туйлын болон туйлын дэд бүсээс бусад газар нутаг дахь цаг уурын байнгын шинж чанар бөгөөд үүнд жил бүрийн хур тунадас, ууршилтын харьцаа 0.05-0.65-ын хооронд байдаг.

**Биохимийн хүчилтөрөгчийн хэрэгцээ:** Органик зүйлийг усан дотор задлах биологийн үйл явцад хэрэглэгдэх хүчилтөрөгчийн тоо хэмжээ. Энэ хэрэгцээ их байх тусам органик бохирдлын зэрэг их байна.

**Биологийн төрөл зүйл:** Амьд организмын дундах олон шинжит байдал болон тэдэнд тохиолдож буй экологийн цогц байдлыг илэрхийлнэ. Үүнд янз бүрийн экосистем, зүйл, генүүд багтана.

**Хөх үзүүлэлт:** Ус болон усны нөөцийн бүх хэлбэрийг илэрхийлнэ.

**Хүрэн үзүүлэлт:** Аж үйлдвэр, хотжилт, тээвэр, эрчим хүчний эх үүсвэрээс үүдсэн бохирдол, тэдгээрийн дан болон хавсарсан үр дагавар, хамгаалалтын арга хэмжээг тодорхойлно.

**Цаг уурын өөрчлөлт:** Цаг уурын нэг нөхцөл байдлаас нөгөө байдлын хоорондох үлэмж хэмжээний өөрчлөлтийг илтгэх бөгөөд зарим тохиолдолд “цаг уурын өөрчлөлт”-ийг “дэлхийн дулаарал” гэсэн ухагдахуунтай ижил утгаар хэрэглэдэг боловч эрдэмтэд энэ ухагдахууныг цаг уурын байгалийн өөрчлөлтийг оруулах илүү өргөн утгаар хэрэглэхийг тэмүүлдэг.

**Уссан хүчилтөрөгч:** Загас болон усны бусад амьдралд амин чухал хийгээд эвгүй үнэрээс сэргийлэхэд хангалттай усан дахь чөлөөт хүчилтөрөгч. Уссан хүчилтөрөгчийн түвшин нь усан дахь зохих амьдралыг дэмжих усны чадварын хамгийн чухал үзүүлэлтэд тооцогддог. Хаягдал ус юүлэгдэж байгаа усан дахь хүчилтөрөгчийн хэмжээг зохих түвшинд байлгахын тулд хаягдал усны хоёрдогч болон түүнээс ч илүү шатны цэвэрлэгээг хийдэг.

**Цөл:** Жилд дунджаар 25 см-аас доош хэмжээний бороо хур ордог бүс нутаг юм. Цөл нь гол төлөв дэлхийн умард хагаст Матрын зам /Tropic of Cancer/ орчимд, өмнөд хагаст Мэлхийн зам /Tropic of Capricorn/ орчимд тохиолддог.

**Ган гачиг:** Хур тунадас хэвийн хэмжээнээс үлэмж бага үед тохиолддог байгалийн үзэгдэл бөгөөд газрын нөхөн үржлийн системд ноцтойгоор нөлөөлдөг усны тэнцвэргүй байдлыг үүсгэдэг.

**Хуурай газар:** Бага болон тогтмол бус хур бороотой, ууршилт ихтэй мөн циклоны ган гачигт өртөмтгий онцлогтой хуурай, хагас хуурай экосистем.

**Урсац:** Цэвэрлэх байгууламж, бохир усны суваг эсвэл үйлдвэрийн газраас гадагш урсаж буй цэвэрлэгдсэн болон цэвэрлэгдээгүй хаягдал ус. Энэ нь ерөнхийдөө гадагын ус руу нийлүүлэн хаяж буй хаягдал ус юм.

**Устах аюулд өртсөн зүйлүүд:** Хүний үйл ажиллагаа болон тэдгээрийн амьдралын орчин дахь байгалийн бусад өөрчлөлтийн улмаас мөхөх аюул учраад байгаа амьтан, шувуу, загас, ургамал болон өөр бусад амьд организмууд.

**Хээр тал:** Янз бүрийн өвс ургамлаас бүрдсэн задгай, тасралтгүй үргэлжлэх газар нутаг.

**Ногоон үзүүлэлт:** Хөдөө аж ахуй эрхлэх, ойг устгах, газрыг өөрчлөх болон хуулиар хамгаалагдсан зүйлүүдийг устгах зэргээс үүдсэн байгаль орчны үр дагаврыг тодорхойлно.

**Амьдрах газар:** Популяцийн /хүн, амьтан, ургамал, бичил организм/ амьдарч буй газар, түүний эргэн тойрон дахь амьд болон амьгүй байгаль.

**Аюултай хог хаягдал:** Буруу хэрэглэвэл хүний эрүүл мэнд болон байгаль орчинд аюул учирч болох нийгмийн дагалт бүтээгдэхүүн.

**Хаягдал булах нүх:** Газраар тархсан аюулгүй хатуу хог хаягдлыг бага хэмжээгээр цуглуулан устгах газар бөгөөд ажлын өдрийн дараа уг нүхийг таглана.

**Азотын давхар исэл:** Азотын исэл агаар мандалд хүчилтөрөгчтэй нэгдсэний дүнд үүсэх ба энэ нь фото-химийн утааны гол бүрэлдэхүүн болдог.

**Пестицид:** Аливаа шавьжаас сэргийлэх, устгахад чиглэсэн бодис болон тэдгээрийн хольц.

**Бохирдуулагч:** Ерөнхийдөө, байгалийн нөөц болон хүн, малын болон экосистемийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг байгальд хаягдаж буй бодис юм.

**Тусгай хамгаалалттай газар нутаг:** Хуулиар буюу бусад үр ашигтай арга хэрэгслээр зохицуулагдсан байгалийн болон соёлын нөөцтэй биологийн төрөл зүйлийг хамгаалах, өсгөн үржүүлэхэд зориулагдсан газар/нуур бүхий талбай.

**Бэлчээр:** Өвс, өвсөрхөг ургамал, тэжээл болон бутлаг ургамал голлосон экосистем.

**Хайлалт:** Газраас хайлж гол горхи буюу газаргуугийн усанд нийлдэг хур тунадас (цас хайлах, усжуулалтын ус). Эдгээр нь агаар болон газраас нийлүүлэгдэж буй усанд бохирдуулагчийг нийлүүлнэ.

**Давсжилт:** Гадаргуугийн болон гүний цэвэр усанд давстай ус орох явдал.

**Заг:** Төв Азийн цөлийн бүсэд орших бут/жигжиг мод.

**Бохир ус:** Орон сууц болон худалдааны эх үүсвэрээс бохир усны шугам сүлжээнд хаягдаж буй хог болон хаягдал ус.

**Хөрсний элэгдэл:** Газар тариалан, суурин болон үйлдвэрийн хөгжил, зам барилга, уул уурхай болон мод бэлтгэлтэй холбоотой газрыг цэвэрлэснээс үүсэх газрын гадаргуугийн усаар бүрхэлт.

**Хатуу хог хаягдал:** Цогц болон заримдаа аюултай бодис агуулдаг хотын хаягдлаас эхлээд үйлдвэрийн хаягдал хүртэлх шингэн- бус, уусдаггүй материал.

**Хээр:** хуурай тал газар.

**Хүхрийн давхар исэл (SO<sub>2</sub>):** Чулуужсан нүүрсийг шатаах явцаас үүсдэг хүнд, хурц үнэртэй, өнгөгүй, агаарын хийн бохирдуулагч.

**Нийт нян:** Хүний, халуун- болон хүйтэн цустай амьтдын нарийн гэдсэнд олон тоогоор амьдрах харьцангуй хортой микроорганизмуудын цуглуулга. Амьтдын үржих материалаар бохирддог усан орчинд байдаг энэхүү цуглуулгын нэг өвөрмөц дэд бүлэг нь үрждэг нян юм.

**Усны чанарын стандарт:** Усны биетийн ашиглалт болон тогтоосон хэрэглээг хангах усны чанарын шалгуурыг бий болгосон стандарт.

*Эх үүсвэр: АНУ-ын Байгаль орчныг хамгаалах агентлагийн “Байгаль орчны нэр томъёо”, 1997 оны 12 дугаар сард хянасан; НҮБХХ-ийн Цөлжилт, гантай тэмжсэх байгууллага*

Монгол улсын талаархи товч мэдээлэл

Газарзүй	Эдийн засаг ба нийгэм
<p><b>Байршил:</b> Зүүн Ази, Хятад болон ОХУ-ын дунд</p> <p><b>Нийт нутаг дэвсгэр:</b> 1.565 сая хавтгай дөрвөлжин км</p> <p><b>Хилийн зааг:</b> Нийт: 8,161.9 км</p> <p><b>Улсын хил:</b> Хятад 4,676.9 км Орос 3,485 км</p> <p><b>Өндөрлөг газрын туйл:</b> Хамгийн намхан цэг: Хөх нуур 518 м; Хамгийн өндөр цэг: Найрамдлын оргил 4,374 м</p> <p><b>Эрдэс баялгийн нөөц:</b> газрын тос, нүүрс, зэс, молибден, гянт, фосфат, тугалга, никель, цайр, алт, мөнгө, төмөр</p> <p><b>Газар ашиглалт:</b> Тариалангийн газар: 5.7 хувь Бэлчээр: 81 хувь Ой бүхий газар: 11.4 хувь Бусад: 1.9 хувь (2000 онд тооцоолсноор)</p> <p><b>Усжуулагдсан талбай:</b> 800 хавтгай дөрвөлжин км (1993 онд тооцоолсноор)</p> <p><b>Цаг агаар:</b> эх газрын (солигдмол улиралтай)</p> <p><b>Улсын нийслэл:</b> Улаанбаатар</p> <p><b>Засаг захиргааны нэгж:</b> 21 аймаг (орон нутаг), Аймаг гэдэг нь хамгийн том улсын дэд засаг захиргааны нэгж юм; Монгол улс 21 аймагт хуваагддаг. Аймгийн дараахь улсын дэд засаг захиргааны нэгжийн дараа сум (дүүрэг) орно. Сум нь баг (дэд дүүрэг)-г хуваагдана. Улсын нийслэлд тойргийг дүүрэг, хороо гэж нэрлэгддэг.</p> <p><b>Төсвийн жил:</b> 1 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 31.</p> <p><b>Тусгаар тогтнол:</b> 1921 оны 7 дугаар сарын 11 (Хятадаас)</p>	<p><b>ДНБ:</b> 4.7 сая ам. доллар (2000 онд тооцоолсноор)</p> <p><b>ДНБ-ний өсөлт:</b> 1 хувь (2000 онд тооцоолсноор)</p> <p><b>ДНБ-ний бүтэц, салбараар:</b> Хөдөө аж ахуй: 36 хувь Үйлдвэр: 22 хувь Үйлчилгээ: 42 хувь (2000 онд тооцоолсноор)</p> <p><b>Мөнгөний нэгж:</b> Төгрөг; 1 ам. доллар = 1,097 төгрөг</p> <p><b>Ханшгүйдэл байдал:</b> 200 ам. доллар (1998 онд тооцоолсноор) <b>Үйлдвэрийн бүтээгдэхүүний өсөлтийн түвшин:</b> 2.4 % (2000 онд тооцоолсноор)</p> <p><b>Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн:</b> улаан буудай, арвай, төмс, малын тэжээл; хонь, ямаа, үхэр, тэмээ, адуу</p> <p><b>Экспортын нийт бүтээгдэхүүн:</b> 454.3 сая ам. доллар (1999 онд тооцоолсноор) <b>Экспортын түншүүд:</b> Хятад 60%, АНУ 20%, ОХУ 9%, Япон 2%</p> <p><b>Импортын нийт бүтээгдэхүүн:</b> 510.7 сая ам. доллар (1999 онд тооцоолсноор) <b>Импортын түншүүд:</b> ОХУ 33%, Хятад 21%, Япон 12%, БНСУ 10%, АНУ 4% (1999 онд тооцоолсноор)</p> <p><b>Хүн ам, жилийн дунд:</b> 2,654,999 (2001 онд тооцоолсноор) <b>Хүн амын өсөлтийн түвшин:</b> 1.4 хувь (2001 онд тооцоолсноор) <b>Ядуурал (нэн ядуу):</b> 40% (2000 онд тооцоолсноор) <b>Төрөлтийн түвшин:</b> 21.8 төрөлт/1,000 хүнд (2001 онд тооцоолсноор) <b>Үхэлтийн түвшин:</b> 7.1 үхэлт/1,000 хүнд (2001 онд тооцоолсноор) <b>Нялхсын эндэгдлийн түвшин:</b> 53.5 үхэлт/1,000 амьд төрөлтөнд (2001 онд тооцоолсноор)</p> <p><b>Дундаж наслалт:</b> 64 жил</p> <p><b>Аюулгүй цэвэр усны хангамж:</b> нийт хүн</p>

	амын 60% <b>Ариун цэврийн хангамж:</b> нийт хүн амын 25 хувь  <b>Нийт хүн амын бичиг үсэг мэдэх явдал:</b> 97%
--	---